

## Улс төрийн онолын тухай асуудалд

(Цуврал өгүүллийн хоёрдугаар)

Ж.Жаргал

МУБИС-ийн Түүх, нийгмийн ухааны  
сургуулийн Улс төр судлал, социологийн  
тэнхмийн багш, докторант

Улс төрийн онол ба улс төрийн үзэл суртал хоорондоо тодорхой харьцаанд оршиж, бие биедээ нөлөөлж нэвтрэлцнэ. Үүгээр тэдгээрийн нийтлэг ба ялгаа, тус бүрийн нь онцлог шинж илэрч харагддаг байна. Улс төрийн үзэл суртал бол нийгмийн байгууллыг бүхэлд нь болон түүний социал, улс төр, эдийн засаг, оюун санааны амьдралын байгаа бодит байдал хийгээд тэдгээрийг цаашдаа хэвээр байлгаж бэхжүүлэх, эсвэл хувиргаж өөрчлөх зорилтыг нийгмийн тодорхой анги, давхрааны язгуур эрх ашиг, байр суурийн үүднээс системтэй тусган илэрхийлж томъёолсон улс төрийн онол, үзэл санаа, үндэслэлүүдийн нийлбэр цогц байдаг. Улс төрийн үзэл сурталыг тухайн анги давхрааны төлөөлөгч, тусгайлан бэлтгэгдсэн үзэл сурталч буюу мэргэжлийн хүмүүс, сэтгэгчид боловсруулдаг. Эндээс улс төрийн онол ба үзэл суртал хоорондоо хоёр гол зүйлээр, нэгд, нийгмийн бодит байдлыг улс төрийн онолын хэлбэрээр тусгадаг, хоёрт тэдгээрийн аль алиныг мэргэжлийн эрдэмтэн сэтгэгчид боловсруулдагаараа ижил төстэй болох нь мэдрэгдэж байна. Үүгээрээ энэ хоёр бие биедээ багагүй хэмжээгээр харилцан нөлөөлж түүнийгээ мөн тодорхой түвшинд харилцан тусгадаг ажээ. Тухайлбал улс төрийн онолын судалгаа боловсруулалт, үнэлэлт дүгнэлт, ерөнхий үзэл баримтлал нь улс төрийн үзэл сурталын онолын үндэслэл, үзэл санааны чиг баримжаа болдог, нэг үгээр хэлбэл түүнийг тодорхой хэмжээгээр онолын агуулгатай, судалгаа шинжилгээний шинжтэй болгодог. Нөгөөтэйгүүр тухайн нийгэм, цаг үед зонхилох байр суурь, нөлөөтэй болж тогтон үйлчилж буй улс төрийн үзэл суртал нийгмийн улс төр, оюун санааны амьдралд, ялангуяа нийгмийн ухаан, улс төрийн сэтгэлгээ, онолд тодорхой хэмжээгээр нөлөөлж тэдгээрийн үзэл санаа, шинж агуулгыг үзэл сурталын элементтэй болгодог, өөрөөр хэлбэл улс төрийн аль нэг онолд нийгмийн ноёлогч, эсвэл зонхилох байр суурьтай анги, давхрааны эрх ашиг, хүсэл зориг онолын шинж хэлбэртэйгээр тусгалаа олсон байдаг. Өрнөдийн эрдэмтэдийн тодорхой хэсэг нь орчин үеийн өндөр хөгжилтэй улс орнуудын нийгэм нь бүхэлдээ ардчилагдсан, нийтийн сайн сайхан байдал, тэгш эрх, эрх чөлөө хангагдсан учираас дарлагч дарлагдагч, мөлжигч мөлжигдөгч анги давхраа гэж байхгүй болсон, тиймээс улс төрийн үзэл сурталын төгсгөл ирж байгаа бөгөөд өнөөгийн улс төрийн онолуудын үзэл санаа, агуулга нь үзэл суртлаас ангид, “тунгалаг” болж байна гэж үздэг нь хэрэг дээрээ эргээд үзэл сурталын зорилго бүхий халхавч байгааг мэргэжлийн эрдэмтэн судлагчид олж харахад төдийлөн бэрхшээл төвөгтэй биш билээ.

Улс төрийн онол ба үзэл сурталын зарим том урсгал чиглэл бүр анхнаасаа улс төрийн сэтгэлгээний нэгэн нэгдмэл үйл явцын хүрээнд нэг зоосны хоёр тал мэт хоорондоо салшгүй холбоотойгоор боловсрогдож гарсан, өнөө үед ч нягт харилцан нөлөөлөлтэй байгаа, гэхдээ хөгжлийн явцад онол ба үзэл сурталын тал нь зохих хэмжээгээр ялгарч, тус бүртээ харьцангуй бие даан оршиж байгаа баримт ч бий бөгөөд түүний тод жишээ, илэрэл бол либерализм, консерватизм, марксизм юм. Гэвч улс төрийн онол ба улс төрийн үзэл сурталыг нийгмийн сэтгэлгээний ерөнхий дэвсгэр суурин дээр зэрэгцүүлэн тавьж, гол зорилго,

гүйцэтгэх үндсэн чиг үүрэгээр нь харьцуулан үзвэл энэ хоёр мөн чанараараа зарчмын ялгаатай болно. Тэр ялгаа бол улс төрийн онол нь улс төрийн үзэгдлийг байгаа бодит байдлаар нь судлаж танин мэдэх, ойлгохыг зорьдог, тэгснээрээ бодит үнэнийг илүү эрхэмлэдэг бол үзэл суртлын хувьд улс төрийн амьдралын бодит үнэн гол зүйл биш, харин нийгмийн тухайн тодорхой анги, даврхаа, улс төрийн хүчний эрх ашиг, байр суурийг илэрхийлэх, зөвтгөж хамгаалах явдал хамгийн чухал зүйл болж тавигддаг байна. Энэхүү том ялгаа зааг улс төрийн сэтгэлгээний тэдгээр хоёр талын нэгийг чухамдаа улс төрийн онол, нөгөөг нь улс төрийн үзэл суртал болгодог ажээ.

Улс төрийн онол нь дээр дурдсан мэдлэг ухаануудын зэрэгцээ нийгмийн тухай хамгийн ерөнхий онол болох онолын ерөнхий социологи, нийгмийн философитой уялдаа холбоотой. Эдгээр ухаан хүний нийгмийн бүтэц, зохион байгуулалт, оршин тогтнол, хөгжлийн зүй тогтол, механизмын тухай бүхэл, метаонолын түвшингийн ерөнхий мэдлэг ухааныг боловсруулан бүтээдэг нь улс төрийн онолд ихээхэн ач холбогдолтой болно. Аливаа системийг бүхэлд нь танин мэдэхийн тулд түүний хэсэгүүдийг сайтар таних, хэсгүүдийг танихыг тулд бүхэлийг тодорхой хэмжээгээр танин мэдсэн байх шаардлагатай. Нарийн нийлмэл юмс үзэгдэлийг тийнхүү танин мэдэх зөрчилтэй, хоёр талтай үйл явцыг “герменевтикийн тойрог” гэж нэрлэдэг. Түүнийг нийгмийн танин мэдэхүйд буулгаж үзвэл нийгмийн тухай нэгдмэл, ерөнхий мэдлэг бүтээхийн тулд нийгмийн эдийн засаг, социаль, улс төр, оюун санааны бүрдэл хэсгүүдийг судлаж, түүгээр бий болсон мэдлэг, ойлголтыг нэгтгэн дүгнэх замаар тэдгээрийн нэгдлийн тухай буюу нийгмийн тухай урьдчилсан ерөнхий ойлголт бий болгох, түүнийг эргүүлж хэсгүүдийг нарийвчлан шинжилж үнэн магадтай, тодорхой мэдлэг боловсруулахад хэрэглэх, тийнхүү гаргаж авсан тодорхой мэдлэгийн үндсэн дээр нийгмийн тухай ерөнхий ойлголт, онолыг нягтлаж гүнзгийрүүлэх шаардлага бүхий нийгмийн танин мэдэхүйн олон талтай, тэдгээр нь хоорондоо нягт харилцан нөлөөлөлтэй үйл явцын дүр зураг харагдна. Тийм учираас улс төрийн онол, онолын социологи ба нийгмийн философи нь тус бүрийнхээ хөгжлийн явцад бие биеийн ололт амжилт, шинэлэг үзэл санаа, дүгнэлтэд байнга харилцан анхаарч “хамтран ажиллах” хэрэгтэй болдог байна.

Эрдэмтэд улс төрийн онолын уг чанарыг тус бүртээ өөр өөр талаас нь судлан илэрүүлэхийг оролдож түүнээс гарсан ойлголтын дагуу янз бүрийн үзэл санал хэлдэг байна. Тэдгээрийг анхаарч авч үзэх нь улс төрийн онолын шинж агуулгыг тал бүрээс нь шинжилж танин мэдэхэд тус дөхөм болно. Тийм олон янзын санал, хандлагуудын дотроос дараах дөрвөн саналыг дурдаж тэмдэглүүштэй юм.

Эрдэмтэдийн зарим нь улс төрийн онолыг боловсрогдож хөгжсөн түүхийн үйл явцын талаас нь түлхүү авч үзээд улс төрийн онол гэдэг бол ерөөс улс төрийн сэтгэлгээний түүхэнд хэн гэдэг сэтгэгч ямар үзэл санаа гаргаж томьёолон тавьсан вэ гэдэгт хариу болдог системчлэгдсэн лавлага бүхий тайлбар юм гэсэн санал хэлдэг байна. Үүнээс өөр үзэл бодолтой эрдэмтэд, энэхүү санал нь улс төрийн онолыг тийнхүү улс төрийн сэтгэлгээний түүхтэй холбон авч үзэж байгаа нь зөв зүйтэй юм. Учир нь улс төрийн аль ч онол өөрийн түүхтэй байдаг бөгөөд түүний агуулга, үзэл баримтлалыг аль болохуйц бүрэн гүйцэд танин мэдэж ойлгох, үнэлэлт дүгнэлт өгөхийн тулд түүний үүсэл, төлөвшил хөгжлийн түүхэн замналыг нягтлан авч үзэх хэрэгтэй болдог, гэхдээ энэ нь асуудлын зөвхөн нэг тал бөгөөд түүгээр улс төрийн онолын уг чанар, агуулгыг бүхэлд нь төлөөлүүлэн ойлгоно гэвэл учир дутагдалтай байх болно,

тиймээс асуудалд өөр, мөн чанарлаг талаас нь хандаж судлах хэрэгтэй гэсэн санал гаргажээ.

Хоёрдугаарт, зарим эрдэмтэн улс төрийн онол гэдэг бол ерөөс улс төрийн юмс үзэгдэл, үйл явц хийгээд тэдгээрийн үр дүнд цугларан хуримтлагдсан эмпирик баримт, мэдээ материалыг системчлэх, нэгдмэл, тодорхой логикт оруулж бүхэл байдлаар ойлгох арга хэрэгсэл юм гэж үздэг байна. Ер нь аливаа онол, түүний дотор улс төрийн онол тийм үүрэг гүйцэтгэдэг сэтгэхүйн чухал арга хэрэгсэл, түүгээр ч үл барам улс төрийн танин мэдэхүйн зохион байгуулалттай, боловсронгуй дээд хэлбэр болох нь маргашгүй үнэн болно. Гэвч улс төрийн онолыг зөвхөн эмпирик баримтыг системчлэх хэрэгсэл, логик бүтэц болох талаас нь ойлговол түүний хамгийн гол мөн чанарлаг агуулга болох улс төрийн ахуйг онолын түвшинд тусгаж, танин мэдэж ойлгосон нарийн гүнзгий уг чанар нь бүдэгэрч, анхаарлын гадна үлдэхэд хүрнэ гэж эрдэмтэдийн өөр нэг хэсэг дээрхи саналыг шүүмжилсэн нь зөв юм.

Гуравдугаарт, улс төрийн онол гэж нэрлээд байгаа зүйл бол үнэндээ сэтгэхүйн парадигм юм гэсэн санал байна. Парадигм нь шинжлэх ухааны философийн (философия науки) гол ойлголтын нэг бөгөөд агуулгаараа эрдэмтэдийн тодорхой хамтлагаас боловсруулж, шинжилгээ судалгааны явцад баримталдаг онол, арга зүйн үндэслэл, итгэл үнэмшил, үнэт чанар, судалгааны арга техникийн цогц нийлбэр юм. Парадигм нь шинжлэх ухааны асуудлыг дэвшүүлэн тавьж томъёолох, сонгох, судалж шийдвэрлэх үлгэр загвар болдог, шинжлэх ухааны тухайн дэг сургууль, уламжлалыг бий болгох, хадгалж хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг, хэрэглэгдэх хүрээ, агуулгаараа онолоос өргөн далайцтай ажээ. Парадигмын тухай үзэл баримтлалыг үндэслэсэн Т.Куны үзснээр парадигм нь онолын ерөнхий суурь дэвсгэр болдог бөгөөд тухайн парадигм өөрчлөгдсөнөөр түүнд үндэслэсэн онол эрс өөрчлөгддөг байна. Эндээс үзвэл улс төрийн онолд парадигмын үүднээс хандаж судлах нь нэг талаас түүний янз бүрийн урсгал чиглэл, дэг сургууль, үзэл санааны уламжлал, шинэчлэлийг нарийвчлан шинжилж, танин мэдэхэд чухал ач холбогдолтой байх боловч нөгөөтэйгүүр улс төрийн онолыг парадигмтай адилтгах нь түүний тодорхой агуулга, багтаамжийг хэт өргөсгөж задгайруулах, чухам өөрт нь оногдсон хүрээ, онцлог шинжийг нь алдагдуулахад хүргэнэ. Тиймээс зарим эрдэмтний энэхүү үзэл саналыг бүрэн зөвшөөрөх аргагүй юм.

Дөрөвдүгээрт, Норвегийн эрдэмтэн И.Галтунг, улс төрийн онол нь улс төрийн амьдралыг тусгаж илэрхийлсэн мэдлэг, ойлголт болохоосоо тодорхой хэмжээгээр тогтож хэвшсэн улс төрийн сэтгэхүй, санаа бодролын маяг (стиль мышления) болох нь илүү давамгай болно гэжээ. Эл үзэл улс төрийн онолыг сэтгэхүйн хэв маяг гэж ойлгосон нь ихээхэн өрөөсгөл хандлага болох нь тодорхой боловч түүнд анхаарал хандуулж, лавлан авч үзвэл зохих нэгэн чухал санаа байгаа ажээ. Тэр нь юу вэ гэвэл И.Галтунг, ер нь нийгмийн ухаан бүхэлдээ, түүний дотор улс төр судлал нь оюун сэтгэхүйн тодорхой арга маягтай байдаг гэж үзээд “саксоны”, “тевтоны”, “галлийн”, “ниппоны” (японы) гэсэн үндсэн дөрвөн маягийг ангилан заажээ. Галтунг сэтгэхүйн маяг гэдэг бол онол, үзэл баримтлал боловсруулан бүтээдэг эрдэмтэн сэтгэгчдийн сэтгэхүй, бодрол бясалгалын тодорхой хэв шинж, төлөв байдал, онцлог мөн бөгөөд түүнийг түүхэн тодорхой эрин цагийн хүрээн дэх нийгэм-соёлын хүчин зүйлс нөхцөлдүүлж байдаг гэж үзжээ (6). Тэрбээр үүгээрээ эрдэмтэн сэтгэгчдийн боловсруулан бүтээсэн нийгмийн болон улс төрийн онол сургаалууд мөн адил тодорхой ангилал бүхий маягтай байдаг гэсэн санааг давхар хэлсэн байна.

Галтунг, сэтгэхүйн дээр дурдсан дөрвөн маягаас “галлийн” маяг нь романы орнуудын нийгмийн сэтгэлгээнд, “тевтоны” маяг нь герман хэлтэй орнуудад зуршмал байсан төдийгүй дэлхийн II дайны дараа марксист сургаал ба соёлын харилан нөлөөллөөр Зүүн Европын орнуудад ч дэлгэрч хэвшсэн гэжээ. Сэтгэхүйн эл хоёр маяг нь эмпирик ойлголт, тодорхой судалгааг биш, санаалаг загвар, хэв маягийг (М.Веберийн томъёолон гаргасан “идеальный тип”) чухалчилж, гол болгож хэрэглэдэг гэж тэрбээр үзсэн байна.

Зарим эрдэмтэн Ж.Галтунгийн заасан сэтгэхүйн маягийн загваруудыг Европын томоохон орнуудын улс төрийн сэтгэлгээ, онолын төлөв байдалд буулган үзэж тус бүрийн нь шинж чанар, онцлогийг илэрүүлэн гаргахыг оролджээ. Түүний үр дүн болж англи-саксоны орнууд болох АНУ, Их Британы улс төрийн сэтгэлгээнд “саксоны” маяг загвар ерөөсөө илэрээгүй, нийгмийн сэтгэлгээ нь “тевтоны” маягтай гэх Герман, ЗХУ-д дедуктив (ерөнхийгээс тодорхой буюу хэсгийг гаргаж авах) сэтгэхүй адилхан голлодог боловч эдгээр орны шинжлэх ухаан, нийгмийн сэтгэлгээний арга маяг нь төдийлөн нийтлэг, ижил төстэй биш, нийгмийн сэтгэхүйн “галлийн” маягтай гэх романы гол гурван орон болох Франц, Итали, Испаны түүх, соёлын уламжлал өөр өөр байсантай нөхцөлдөж тэдгээрийн нийгэм-улс төрийн сэтгэлгээ хоорондоо ихээхэн ялгаатай болох нь харагджээ.

Хэдийгээр ийм дүр зураг харагдаж байгаа боловч дэлхийн соёл, иргэншил, нийгэм- улс төрийн өөр өөр системд харьяалагддаг янз бүрийн орнуудын нийгмийн сэтгэлгээ, улс төрийн онол сургаалын хэв шинж, онцлог, түүхэн тодорхой төлөв байдал, өөрчлөлт хөгжлийн чиглэлд чухам ямар хүчин зүйл, нөхцөл байдал нөлөөлж нөхцөлдүүлдэг вэ гэдгийг авч үзэж тодруулахад “санаалаг хэв маяг” гэсэн ойлголт чухал ач холбогдолтой ажээ. Түүний дагуу асуудалд хандвал улс орнуудын нийгмийн сэтгэлгээ, улс төрийн онолын хэв шинж, төлөв байдал, онцлогт нөлөөлж тодорхойлж байдаг нийгэм-соёлын чухал хүчин зүйл бол: 1) харьцангуй удаан хугацаагаар оршиж тогтдог нийгмийн болон улс төрийн байгуулал, түүний хүрээнд өрнөдөг улс төрийн үйл явц; 2) соёл, боловсрол, нийгмийн хүмүүжлийн тогтолцоо; 3) тухайн орнуудад улс төрийн шинжлэх ухаан хөгжсөн эсэх, улс төр судлагч эрдэмтэдийн нийгэм дэх байр суурь, нөлөө оролцоо, нэр хүнд; 4) тухайн оронд тогтож хэвшсэн оюун сэтгэхүйн ерөнхий уур амьсгал, орчин нөхцөл – эдгээр болно.

#### **4.Улс төрийн онолын бүтэц**

Улс төрийн онол цогц чанартайн хувьд тодорхой бүтэцтэй байх бөгөөд тэр нь түүний судалгааны үйл явцын **судлах асуудал - судалгааны зорилго – судалгааны үр дүн** бүхий онолын дүгнэлт, санал гэсэн зангилаа чухал бүрдэл хэсэг, шат дарааллын логикоор нөхцөлдөж бий болдог байна. Үүний дагуу улс төрийн онолын судалгаа өөрийн авч үзэх асуудлаа сонгож томъёолох, үндэслэж дэвшүүлэн тавих алхмаар эхэлнэ. Ер нь шинжлэх ухааны судлах асуудал өөрийн уг чанар, нарийн нийлмэл байдал, хэмжээ, гарах үр дүнгээрээ янз бүр байдаг. Онолын суурь судалгааны асуудал нь нарийн нийлмэл, олон талтай, хамрах хүрээ нь өргөн, голцуу байгаль, нийгмийн юмс үзэгдлийн мөн чанар, зүй тогтолыг танин мэдэж илэрүүлэхтэй холбоотой, үр дүн, ач холбогдол нь амьдрал практикт тэр даруйдаа хэрэгжихээргүй, ихэнхдээ онол-танин мэдэхүйн хийгээд ертөнцийг үзэх үзэл, соёлын үүрэг, ач холбогдолтой байдаг. Харин шинжлэх ухааны хавсарга судалгааны асуудал нь эмпирик шинжтэй, үр дүн нь үйлдвэрлэл, практикт шууд нэвтэрч бүтээгдэхүүн болдогоороо онцлогтой. Үүнтэй уялдуулж улс төрийн шинжлэх ухаан мөн адил хавсарга, тодорхой судалгаа хийдэг бөгөөд тэр нь улс төрийн амьдрал практикаар тулгамдан

тавигддаг, тухай бүрт нь шийдвэрлэвэл зохих тодорхой, цаг үеийн шинжтэй зорилтуудыг шинжлэн судлаж хариу тайлбар, санал зөвлөмж өгөхөд чиглэгдсэн байдгийг дурдвал зохино. Тийм эмпирик, тодорхой судалгааны жишээ бол сонгууль болон улс төрийн бусад үйл явдал, нам, хүчнүүд, улс төрчдийн талаархи олон нийтийн санаа бодол, рейтингийн судалгаа юм. Улс төрийн эмпирик, хавсарга судалгааг голцуу социологийн тодорхой судалгааны анкетийн санал асуулга, фокус группын судалгааны аргаар хийдэг.

Улс төрийн онолын судлах асуудлын талаар дээр тоймлож дурдсан бөгөөд энд дараах зарим зүйлийг нэмж товч өгүүлэе. Улс төрийн онолын асуудал нь нийгмийн амьдралын улс төрийн зохион байгуулалтын зүй зохистой, үр ашигтай хэлбэрийг эрж хайсан, түүнд хариу болгож боломжит хувилбарыг онолын үүднээс үндэслэж санал болгосон, түүхэн цаг хугацааны хувьд хэдэн зууны туршид чухал чанараа хадгалж үе үеийн сэтгэгч мэргэдийн анхаарал, бодрол сэтгэлгээний төвд тавигддаг, ялангуяа нийгэм, улс төрийн байгууллын өөрчлөлт, шинэтгэлийн үед чухал болдог, тэгэхдээ аль ч үед байнгын чанартай асуудлууд байдаг. Гэхдээ тэдгээр асуудал нь улс төрийн амьдрал, практикаас тасархай, хэн нэг сэтгэгч эрдэмтнээс санааны зоргоор зохиож томъёолдог хийсвэр зүйл байдаггүй, хэдийгээр томъёологдож, дэвшин тавигдсан хэлбэрээрээ санаалаг загвар байх боловч эцсийн дүндээ нийгэм, улс төрийн амьдралаас ургаж гарсан, түүнтэй шууд ба дам, ил ба далд байдлаар уялдаж холбогдсон, түүнчлэн практикт аль нэг цаг үед ямар нэг хэлбэр хэмжээгээр хэрэгждэг зэрэг шинж чанартай байдаг ажээ.

Улс төрийн онолын уг чанар, агуулгыг илэрхийлж гаргахад түүний судалгааны зорилго, тодорхой зорилтуудыг авч үзэж тодруулах явдал зохих ач тустай болно. Энд юуны өмнө улс төрийн онолч эрдэмтэд ер нь ямар зорилгоор судалгаа хийдэг вэ, тэр нь юугаар нөхцөлдөж хэрхэн тавигддаг вэ гэсэн асуулт гардаг байна. Түүнд хариу тайлбар болгож ихэнх эрдэмтэн, улс төрийн онолын судалгааны нийтлэг, гол зорилго бол нийгмийг зүй зохистой, сайн зохион байгуулах зарчим, арга зам, төсөөлөн буй шударга сайн нийгмийн санаалаг дүр зураг, шинж чанарыг судалгаагаар эрж хайж, онолын үндэслэлтэйгээр гаргаж тавих явдал юм гэсэн санал хэлдэг ажээ. Эндээс улс төрийн онолын агуулга ба онолын судалгааны зорилго хоорондоо нийцдэг нь харагдаж байна.

Улс төрийн онолын судалгааны зорилгод нийгэм, улс төр, эдийн засаг, соёл, шинжлэх ухаан, олон улсын харилцаа зэрэг объектив болон субъектив чанартай олон янзын нөхцөл, хүчин зүйл шууд ба дам байдлаар нөлөөлж нөхцөлдүүлдэгээс дараах хоёр зүй голлох үүрэгтэй ажээ. Нэгдүгээрт, дэлхийн аль ч улс орон хөгжил дэвшилтэй байх, аль ч үндэстэн, ард түмэн өөрийн аж төрж буй нийгэм нь шударга ёс, тэгш эрх, эрх чөлөө, ардчилал тогтсон, нэг үгээр хэлбэл нийгмийн амьдралын улс төрийн зохион байгуулалт нь хүмүүнлэг ардчилсан бөгөөд зүй зохистой байхыг ямагт хүсэж эрмэлздэг. Энэхүү хамгийн чухал, суурь чанартай эрхэмлэлээс улс төрийн онолын судалгааны зорилго ургаж гардаг байна. Энэ нь дэлхийн аль ч орон, ард түмний улс төрийн онолын сэтгэлгээнд нийтлэгээр хамаарна.

Улс төрийн онолын судалгааны зорилго тухайн тодорхой улс орон, түүний нийгэм, ард түмний дээр дурдсан нийгэм-улс төрийн эрхэмлэл, үнэт зүйлээс тийнхүү урган гарч, түүгээр бүхэлдээ нөхцөлдөн тодорхойлогдож байж нийгэм-соёлын болон онол-танин мэдэхүйн үнэ цэнэтэй, үүрэг, ач холбогдолтой болдог, нийт эрдэмтэн сэтгэгчдээр хүлээн зөвшөөрөгддөг байна. Хоёрдугаарт, шинжлэх ухаан, түүний дотор нийгэм, улс төрийн шинжлэх ухааны хөгжил, судалгаа танин мэдэхүйн сэдэл, хөдөлгөгч хүч нь бүхэлдээ материаллаг үйлдвэрлэл,

нийгмийн практикийн хэрэгцээ шаардлага мөн байдагийн зэрэгцээ шинжлэх ухаан хөгжлийнхээ явцад харьцангуй бие дааж, судалгаа, танин мэдэхүй нь нэлээд тохиолдолд өөрөө өөртөө эрхэм зорилго болж өөрийн дотоод хэрэгцээ, логик өрнөлийн дагуу гүнзгийрэн хөгждөг талтай юм. Энэ байдал улс төрийн онолын сэтгэлгээнд бүр ч учир холбогдолтой байдаг. Улс төрийн онолч эрдэмтэд, нэн ялангуяа улс төрийн сэтгэлгээний түүхэнд алдаршин мөнхөрсөн үе үеийн сэтгэгчид өөрсдийн сургаал, онол, ном зохиолоо ямар нэг эзэн хаан, засгийн газар, улс төрийн нам, хүчний захиалга даалгавар, өгсөн үүрэг тушаалаар бүтээж туурвисан гэх баримт бараг байдаггүй, харин өөрсдийн эзэмшсэн мэргэжил, эрдэм чадал, сайн санааны хүсэл зоригоор бүтээж туурвисаар ирсэн нь ёс мэт болж хэвшжээ.

Улс төрийн онолын судалгааны зорилго хэрхэн томъёологдож, яаж тавигдах вэ гэдэгт улс төрийн сэтгэлгээ, судалгаа шинжилгээний тухайн тодорхой дэг сургууль, уламжлал, нийгэм-соёлын бусад хүчин зүйл, түүнчлэн тухайн эрдэмтний нийгэм-улс төрийн байр суурь, үзэл бодол зохих хэмжээгээр нөлөөлдөг байна. Нийгмийн амьдралын улс төрийн зохион байгуулалт, шударга ёс, ардчилал, тэгш эрх, эрх чөлөө, нийгмийн баялга бусад үнэт зүйлсийн хувиарлалт, төрийн үүрэг, оролцоо ямар байх ёстой вэ гэх зэрэг асуултад улс төрийн онолч эрдэмтэд өөр өөр талаас нь хандаж, мөн өөр өөр, түүгээр ч үл барам эсрэг тэсрэг хариу тайлбар, үзэл бодол гаргаж тавьдаг нь дурьдсан зүйлтэй ихээхэн холбоотой байдаг.

Улс төрийн онолын сэтгэлгээ, судалгааны үр дүн, “бүтээгдэхүүн” болж улс төрийн аль нэг тодорхой чиглэлийн онол, томоохон үзэл баримтлал боловсрогдож гардаг, түүний томъёологдож илэрхийлэгдэх, биежих хэлбэр нь голцуу эрдэм шинжилгээний нэгэн сэдэвт бүтээл, заримдаа хэмжээгээрээ бага боловч үзэл санаа, агуулга нь гүнзгий, нэн шинэлэг бэсрэг товхимол, түүгээр ч үл барам эрдэм шинжилгээний өгүүлэл байдаг жишээтэй. Улс төрийн онол сэргэж, судалгаа боловсруулалт нь идэвхжсэн үе гэгддэг 1970-аад оноос хойш нийтлэгдэж гарсан, энэ үед улс төрийн онолын хөгжилд жинтэй хувь нэмэр болсон олон бүтээлээс нэрд гарч алдаршсан зарим суурь зохиолыг дурдвал: Ж.Роулз. Шударга ёсны онол (J.Rawls: A Theory of Justice. Cambridge, 1971), Чарльк Р.Бейц. Улс төрийн онол ба олон улсын харилцаа (Charles Beitz: Political Theory and International relations, 1979), Жонн Данн. Ирээдүйтэй нүүр тулсан Өрнөдийн улс төрийн онол (John Dunn: Western Political Theory in Face of the Future, 1979), Р.Нозик. Анархи ёс, төр, утопи үзэл (R.Nozick: Anarhia, Stato, Utopia, 1981), М.Новак. Ардчилсан капитализмын үзэл санаа (M.Novak: The Spirit of Democratic Capitalism. New York, 1982), М.Сэндел. Либерализм ба шударга ёсны зааг (M.Sandel : Liberalism and the Limits of Justice, 1982), М.Уолцер. Шударга ёсны хүрээ (: Michael Walzer: Spheres of Justice, 1983), Д.Хэлд. Ардчилсан загварууд (David Held: Models of Democracy, 1987), мөн түүнчлэн улс төрийн онол ба орчин үеийн төр (Political Theory and the Modern State, 1989), түүнчлэн хамтын эмхтгэл бүтээл болох “Орчин үеийн улс төрийн онол: зангилаа чухал санал шүүмжлэлүүд” ( Modern Political Theory – Key De-Bates, 1988), Ф.А.Хаек. Философи, улс төр судлал, эдийн засаг дахь шинэ судлал ба үзэл санааны түүх (New studies in Philosophy, Politics, Economics and the History of Ideas, 1978), мөн түүний Хөнөөлтэй бардам зан (The Fatal Conceit, 1990), орос хэлээр гарсан “Орчин үеийн улс төрийн онол” (Современная политическая теория. Автор-составитель Д.Хэлд. Перевод с английского под общей редакцией В.И.Даниленко. М.,2001); Т.А.Алексеева. Орчин үеийн улс төрийн

онолууд. Өрнөдийн туршлага (Цуврал лекц) (Т.А.Алексеева. Современные политические теории. Опыт Запада (Курс лекций). М.,2000).

Онолын томоохон бүтээлүүд нийтлэгдэн гарсны дараа эрдэмтэдийн анхаарлыг татаж үзэл бодол, хийж буй судалгааны ажилд нь янз бүрийн байдлаар багагүй нөлөөлдөг, тухайлбал зөвтгөл магтаал, маргаан, шүүмжлэл үүсгэх, шинэ асуудал дэвшүүлэн тавихад нөлөөлөх зэргээр улс төрийн онолын цаашдын хөгжилд түлхэц өгдөг байна. Улс төрийн онолын шинэлэг, гүнзгий үзэл санаа агуулсан зарим суурь бүтээл улс төрийн философи, улс төрийн шинжлэх ухаан, нийгмийн болон түүхийн философи, улс төрийн гэсэн тодотголтой бусад салбар ухаанд ч ихээхэн нөлөөлдөг, тухайн бүтээлийн эргэн тойронд өөр олон ном бүтээл зохиогдорж диссертацийн ажил бичигддэг жишээ туршлага цөөнгүй бий. Түүний тод жишээ болгож Ж.Роулзын “Шударга ёсны онол”-ыг дурдаж болно. Эдгээр нь улс төрийн онол улс төрийн практиктай эцсийн дүндээ холбоо хамааралтай байх боловч тодорхой хэмжээгээр харьцангуй бие дааж өөрийн дотоод логик, өрнөлийн аясаар хөгждөгийг харуулна.

### **5.Улс төрийн онолын судалгаанд хэрэглэдэг арга зүй, арга, хандлага**

Улс төрийн онолд түүний судалгааны арга зүй (методология), арга ба хандлага (подход) чухал үүрэгтэй. Манайд гарч буй зарим ном бүтээлд судалгааны арга зүй ба аргыг хооронд нь тэр бүр ялгагдаггүй явдал тохиолддог. Угтаа судалгааны арга ба хандлага хоёр ч хоорондоо багагүй ялгаатай. Шинжлэх ухааны суурь судалгаа, танин мэдэхүйд онолын нэгэн адил арга зүй нэн чухал үүрэгтэй. Учир нь онолын судалгааны ажил бол ерөөсөө арга зүйн утга агуулгатай байдаг. Арга зүй нь судлах асуудал, үзэгдлийг хэрхэн яаж, ямар арга, хандлагаар авч үзэж шинжлэх вэ гэдэг суурь зарчим бүхий үндэслэлийг зааж, судалгааны үйл явц ба түүнд хэрэглэж буй арга, хэрэгсэлүүдийг зөв зүйтэй зохион байгуулах, хүссэн үр дүнд хүрэх боломж олгоно, бүхэлдээ танин мэдэхүйн явцыг өөрийн рефлексстэй, хяналттай, логик чиглэлтэй болгоно.

Судалгааны арга зүй нь судлах объектын шинж чанар, онцлог болон баримталсан онолд тохирч нийцсэн байх ёстой. Судалгаанд урьдчилан баримжаалж сонгосон арга зүй объектын мөн чанарт аяндаа хүргэж судалгааг амжилттай болгоно гэж үзэж болохгүй, судалгааны явцад үл тохирох явдал, зөрчил бэрхшээл үүсч болно. Тиймээс арга зүйн чиг баримжаа, гүйцэтгэж буй үүргийг судалгааны бүхий л явцад байнга хянаж нягтлах шаардлага гарна. Өөрөөр хэлбэл онол ба арга зүй эхнээсээ зөв сонгогдсон, судлагдахууны шинж чанар, онцлогт тохирч нийцсэн байх ёстой. Эдгээр дурдсан ерөнхий зүйл улс төрийн онолын судалгааны арга зүйд мөн адил холбогдож хамаарна.

Тэгвэл орчин үеийн улс төрийн онолын судалгаанд ямар арга зүй баримтлагдаж байна вэ ? Энэ бол ерөнхий асуулт юм. Учир нь улс төрийн онол бол улс төрийн янз бүрийн үзэгдэл, асуудлыг тодорхой чиглэлүүдээр, тэдгээрийн тус бүрт нь тохирсон өөр өөр арга зүй, хандлагаар судалдаг олон янзын урсгал чиглэл бүхий тодорхой онолуудаас бүрэлддэг. Тэдгээр онол хоорондоо олон талаараа холбоотой, багагүй нийтлэг үзэл санаатай байдгийн эрхээр улс төрийн онол гэсэн нийтлэг, ерөнхий нэрээр нэгэн дээвэр дор оршдог. Энэ нь улс төрийн онол янзын онолд нийтлэгээр хэрэглэж болохуйц метатүвшингийн ерөнхий арга зүй байж болох нөхцөлийг бүрдүүлдэг байна. Тэгэхлээр асуудлын гол нь тийм ерөнхий арга зүйг ямар үндэслэл, арга замаар боловсруулах вэ, судалгаанд яаж хэрэглэх вэ гэдэгт оршино. Аливаа судалгаа, түүний дотор ялангуяа онолын судалгаанд баримтлах арга зүйн гол асуулт бол судлагдахуун болж буй тодорхой юм, үзэгдлийг урьдчилсан байдлаар ер нь юу

гэж үзэж төсөөлөх вэ, ямар талаас нь хэрхэн хандах вэ, судалгааны ямар арга хэрэгслийг чухалчилж хэрэглэх вэ гэсэн асуулт болохыг юуны өмнө анхаарч тооцох хэрэгтэй болно. Асуудалд тэр дагуу хандаж авч үзэхийг оролдоё.

Орчин үеийн шинжлэх ухаанд байгалийн жам ёсны үзэгдэл, үйл явцад хандаж авч үзэх үндсэн хоёр янзын арга зүйн ерөнхий хандлага байдаг нь натурализм ба холизм ажээ. Натурализм нь хүн төрлөхтөний түүх, хүний нийгэм бол байгалийн жам ёсны нэг хэсэг бөгөөд тиймээс түүнийг байгаль шинжлэлд хэрэглэдэг судалгааны түгээмэл, ерөнхий аргуудаар судлан шинжилж болно гэж үздэг. Энэ арга зүйгээр хандвал улс төр, түүний янз бүрийн үзэгдэл бол хүний нийгмийн жам ёсны органик бүрэлдэхүүн хэсэг бөгөөд түүнийг нийгмийн шинжлэх ухаанд хэрэглэдэг судалгааны нийтлэг, ерөнхий аргуудаар судлаж танин мэдэж болно гэсэн логик үндэслэл гарна. Гэвч нийгэм, түүний салшгүй хэсэг болох улс төрийг байгалийн хувьсалын шууд үргэлжлэл, амьтны аймагтай нэгэн адил шууд бүрдэл хэсэг хэмээн үзвэл бүдүүлэг натурализмд хальтран орж, нийгэм ба түүний үзэгдэл, үйл явцын байгалиас ялгагдах мөн чанарлаг, зарчмын асар их ялгааг орхигдуулахад хүрнэ. Нийгэм бүхэлдээ, түүний амьдралын бүх хүрээ салбарын үзэгдэл, үйл явцууд чухам хүмүүсийн үйл ажиллагаа, тодорхой зорилго, ухамсар, эрхэмлэл, сонголтоор дамжиж хэрэгжин явагддаг онцлогтой. Тиймээс нийгмийн амьдрал, түүний дотор улс төрийг байгаль шинжлэлд хэрэглэдэг лабораторийн туршилт, урвалж бодис, жин хэмжүүр, микроскопоор шинжлэх аргагүй, түүнийг онолын судалгааны онцгой чухал арга хэрэгсэл болох хийсвэрлэлээр шинжилж таньж мэднэ.

Улс төр бол нэг талаар нийгмийн харьцангуй бие даасан нэн өвөрмөц, өөрийн мөн чанар, зүй тогтолтой идэвхтэй, түүгээрээ нийгэмд бүхэлд нь болон түүний бусад бүрдэл хэсэгт тус бүрт нь эргэж хүчтэй нөлөөлдөг, нөгөөтэйгүүр эдийн засаг, социал хүрээ, соёл, оюун санаа, иргэншил, уламжлал зэрэг нийгмийн институтуудаар нөхцөлдөж тэдгээрийн нөлөө оролцоог өөртөө тодорхой хэмжээгээр тусгадаг. Үүнийг улс төрийн онолын судалгааны арга зүйд буулгаж нямбай анхаарч тооцох хэрэгтэй болно. Энэ дагуу орчин үеийн улс төрийн судалгаа, ялангуяа улс төрийн шинжлэх ухаан өөрийн авч үзэх асуудлыг нийгмийн буюу социологийн хандлага, эдийн засаг, соёл, хүн судлал, сэтгэл судлал, түүх-уламжлал, институционал, функционал, системийн болон бихевиоризмын хандлагаар судлах, өөрөөр хэлбэл улс төрийн үзэгдэлүүдийг эдгээрийн үүднээс хандаж шинжлэх арга зүйг тодорхой хэмжээгээр баримталж байна. Энэ нь улс төрийн аль нэг тодорхой үзэгдэл нийгмийн олон талтай амьдралаар нөхцөлдсөн нарийн нийлмэл, мөн олон талтай болохыг илэрхийлэн гаргах бололцоо олгоно.

Энд өгүүлсэн зүйлтэй уялдуулж судалгааны хандлагын талаар ( approach, method of approach – подход, исследовательский подход) цухас дурдья. Судалгааны хандлага нь судлах объектэд шууд чиглэж, түүнд ямар, аль талаас нь хандаж авч үзэх вэ, шинжилгээнд ямар аргыг голлож хэрэглэх вэ гэдгийг зааж чиглүүлдэг, энэ чанараараа судалгааны арга зүй, аргыг хооронд нь холбож өгдөг, тэдгээрийн аль алины шинж чанар, үүргийг өөртөө тодорхой хэмжээгээр агуулдаг байна. Тиймээс ч судалгааны хандлагыг (тухайлбал социологийн, нийгэм-эдийн засгийн, эсвэл хүн судлал, сэтгэл зүйн хандлага г.м.) холбогдох ном бүтээлд арга зүйн хандлага, эсвэл арга хандлага гэж арга зүй ба аргын аль алинтай нь холбож тодотгосон байдаг.

Холизм (грек хэлний holos – холос – бүхэл гэсэн утгатай үгнээс гаралтай) нь байгаль ертөнцөд тогтолцоот чанартай шинэ цогц бүхэлүүд үүсэн бүрэлдэх бүтээлч хувьсалын үйл явц явагдаж байдаг гэж үздэг философийн сургаал



бөгөөд түүний арга зүйн гол баримтлал бол бүхэл нь түүнийг бүрдүүлдэг хэсэгүүдийн жирийн нийлбэр биш, ер нь нийлбэрээс том, чанарын цоо шинэ шинжтэй, цогц юм гэсэн үзэл санаа болно. Холист арга зүй судлагдахуунд ингэж ханддагаараа арга зүйн индивидуализм буюу юмс үзэгдэлийг хэсэгчилж, хэсэг тус бүрийг судалгааны тодорхой нэг аргаар шинжлэхийг хэрэгсэдэггүй. Холизмын философийн үзэл санаа, арга зүйн баримтлалыг нийгэм судлагч эрдэмтэд нийгмийн шинжлэх ухаанд буулгаж хэрэглэхийг оролдож энэ нь боломжтой юм, учир нь холист онол, арга зүй нь нийгэм хийгээд түүний социал хүрээ, эдийн засаг, улс төр, оюун санааны бүрдэл хэсэгүүд нь бүхэл, цогц чанартай, тэдгээрт макротүвшингийн үйл явц, чиг хандлагууд явагдаж байдгийг судлан илэрхийлэх бололцоо олгоно гэж үздэг байна. Үүгээрээ холист арга зүй улс төрийн онолын судалгаанд ч зохих хэмжээний ач холбогдолтой бөгөөд тэр дагуу эрдэмтэд түүнийг тодорхой хэмжээгээр хэрэглэж байгааг зарим ном зохиолд тэмдэглэжээ (7,22-23).

Холист арга зүйг улс төрийн онолын судалгаанд зориуд хэрэглэх тодорхой хэрэгцээ бүхий бодит шалтгаан ч байгаа ажээ. Тэр талаархи гадаадын эрдэмтэдийн санал бодлоос дурдахад илүүдэхгүй. Америк, Англи, Франц зэрэг орнуудын улс төрийн томоохон онолч эрдэмтэдийн бүтээлийн нэгэн эмхтгэлд арга зүйн чанартай дараах чухал санааг гаргаж тавьсныг утгачилж өгүүлэе.

Улс төр бол нийгэм, улс төрийн ертөнцийн зохион байгуулалттай холбоотой өргөн хүрээний асуудлыг, тухайлбал төрийн байгуулал, эдийн засгийн бодлого, нийгмийн бүтэц, төрийн гадаад бодлого хийгээд олон улсын харилцааг агуулан багтаадаг. Тиймээс нийгмийн ухааны томоохон салбарууд болох улс төр судлал, улс төрийн эдийн засгийн ухаан, социологи, олон улсын харилцааны онол тэдгээрийг тус бүрт нь бие даасан асуудал болгож тусгайлан судалдгийн зэрэгцээ улс төрийн онол мөн өөрийн хүрээнд тэдгээрт тохирсон салбар онолын үүднээс авч үздэг. Энэ нь нийгмийн шинжлэх ухааны ялгаралыг (дифференциация) бий болгох, улс төрийг олон талаас нь авч үзэж нарийвчлан шинжлэхэд нэг хэсэгтээ ач тустай байж үр дүнгээ өгсөн байна. Гэвч нийгмийн амьдралын үзэгдэл, бүрдэл хэсгүүдийг тус тусд нь задлан шинжлэх нь тодорхой хэмжээ хязгаартай бөгөөд задлан шинжилгээний зохих шатад түүний үр дүнг нэгтгэн дүгнэх хэрэгцээ шаардлага зайлашгүй гардаг. Үүний дагуу улс төрийн тухай дээр дурдсан салбар ухаануудын болон улс төрийн олон янзын салбар онолуудын судалгааны үр дүн, гаргаж авсан мэдлэгийг хооронд нь синтезлэж нэгтгэн дүгнэх, нэг үгээр хэлбэл улс төр гэж юу вэ гэдэг асуултад өгөх бүхэл, нэгтгэн дүгнэсэн хариу тайлбар бий болгох цаг болсон. Гэтэл бид өнөөдөр улс төрийн хэсэг бүхий деталуудын талаар илүү олон зүйл мэдэж байгаа хэрнээ улс төрийн бүхэл, цогц чанарын тухай хангалттай мэдлэг, ойлголттой болж хараахан чадаагүй. Тиймээс өнөө үед наандаж улс төр судлал, улс төрийн эдийн засгийн ухаан, социологи, олон улсын харилцааны онол, цаашдаа нийгмийн ухааны бусад салбаруудын бий болгосон улс төрийн талаархи мэдлэг, ойлголтыг хооронд нь шинжлэх ухаанчаар синтезлэж нэгтгэн дүгнэх зайлашгүй шаардлагатай болоод байна гэж дурдсан бүтээлд онцлон заажээ (8,17-19). Энэ нь судалгаа, танин мэдэхүйн холист арга зүйд нэн нийцтэй болохыг олж харахад төвөггүй юм.

Орчин үеийн улс төрийн онолын судалгааны арга зүй өмнөх үеийн уламжлал, танин мэдэхүйн хүч боломжоо дайчлан хэрэглэж байгаагийн зэрэгцээ байгаль, нийгмийн шинжлэх ухааны бусад салбарын арга зүйгээс суралцаж хэрэглэх замаар арга зүйн сан хөмрөгөө баяжуулах, шинэчлэх чиглэлээр хөгжиж байна. Энэ явцад ажиглагдаж байгаа нэгэн гол чиг хандлага

бүхий зүйл бол арга зүй өөрийгөө судалгааны зорилго, чиглэл, үйл явцад тулган хүлээлгэх, дүрэм, хэм хэмжээ тогтоохыг урьдал болгохгүй, гол нь судлах асуудлын нийгэм-соёл, түүхэн шинж чанарыг тодруулж илэрхийлэх, танин мэдэхүйн аппаратыг түүнд уялдуулж нийцүүлэх, судалгааг бүхэлд нь зөв зүйтэй, зохион байгуулалттай, өөрийн хяналт, үнэлгээ, рефлексстэй болгохыг чухалчилж байгаа ажээ.

Нийгмийн ухааны бусад салбарын нэгэн адил улс төрийн онолд судалгааны арга чухал үүрэгтэй болно. Түүнд судалгааны индуктив ба дедуктив, хийсвэрээс тодорхойд дэвшин шилжих, түүхийн ба харьцуулалтын арга зэрэг ерөнхий буюу логик аргууд өргөн хэрэглэгддэг. Улс төрийн онол ба арга хоорондоо нягт харилцан нөлөөлөлтэй байж хүссэн үр дүнд хүргэнэ. Онол нь аргыг зорилго чиглэлтэй хэрэглэхийг хангадаг бол арга нь онолыг боловсруулж бүтээх үйл явцыг үндэслэлтэй, тодорхой механизмтай, хэрэгсэлтэй болгодог байна. Улс төрийн онол олон янзын урсгал чиглэлтэй байдаг бол тэдгээрт хэрэглэгддэг аргууд тийм олон биш, нэг арга хэд хэдэн онолд нэгэн зэрэг хэрэглэгддэг. Өөрөөр хэлбэл судалгааны аль нэг аргаар хэд хэдэн онол боловсруулан бүтээж болно гэсэн үг юм. Гэхдээ энэ нь онолын нэг судалгаанд зөвхөн нэг арга хэрэглэдэг гэсэн үг огт биш бөгөөд ер нь аливаа асуудлын судалгаанд хэд хэдэн аргыг хослуулан хэрэглэж байж үр дүнд хүрдэг.

Улс төрийн онолын үнэн зөв, үндэслэлтэй эсэхийг байгалийн ухааны онол шиг фальсификацийн аргаар шалгах аргагүй. Түүний гол шалгуур бол нийгэм, улс төрийн практик, түүнчлэн бусад эрдэмтэд тухайн онолыг сайшааж, хүлээн зөвшөөрч байгаа эсэх, бас тухайн онолын эмпирик баримтын сан хангалттай эсэх, уг онолын ерөнхий бүтэц, логик үндэслэл, ойлголт, категори, нэр томъёоны цогц нийлбэр буюу шинжлэх ухааны аппаратур нь хэр зэрэг хангалттай, хоорондоо хэр зэрэг уялдаа холбоотой байна вэ гэдгээс шалтгаалдаг байна. Байгалийн ухааны аль нэг онол үнэн зөв, үндэслэлтэй биш нь нотлогдвол цаашдаа судалгаанд хэрэглэгдэхгүй болж няцаагддаг, үүний улмаас түүнд хэрэглэсэн арга “нэр хүндгүй” болох явдал гардаг бол улс төрийн онолд ийм байдал тэр бүр тохиолддоггүй. Улс төрийн аль нэг онол янз бүрийн шалтгааны улмаас үндэслэлгүй, хүч нөлөөгүй болж яваандаа няцаагдсан ч гэсэн түүнийг боловсруулан бүтээхэд хэрэглэсэн арга цаашдаа онолын өөр судалгаанд үр нөлөөтэй хэрэглэгдсээр байдаг онцлогтой. Ер нь шинжлэх ухааны аль ч салбарт түгээмлээр хэрэглэгддэг, шинжилгээ, танин мэдэхүйн үр нөлөөтэй, хүчирхэг хэрэгсэл болж хэвшин тогтсон, хийсвэрлэлийн чанартай логикийн ерөнхий аргуудын үүрэг, ач холбогдол ямагт чухал хэвээр байдаг. Тиймээс асуудлын гол онь тэдгээрийн алийг нь ямар онолд, ямар объектын судалгаанд хэрхэн яаж хэрэглэх вэ гэдэгт оршдог байна. Энэ нь улс төрийн онолын судалгааны аргуудад мөн адил хамаарч холбогдоно.

Энд залгаад дээр өгүүлсэн зүйлийн логик үргэлжлэл болгож улс төрийн онолын судалгаанд хэрэглэж ирсэн арга зүй, аргын түүхэн үйл явцын талаар товч дурдъя. Эрдэмтэд түүнд дараах үндсэн дөрвөн үе шат ажиглагддагийг зааж тэмдэглэжээ. Тэдгээр нь нэгдүгээрт, улс төрийн онолын сэтгэлгээний сонгодог үед (XIX зуун хүртлэх үе) арга зүйн логик-философи, ёс суртахуун-үнэлэмжийн хандлага хийгээд дедуктив арга голлосон; хоёрдугаарт, XIX зууны дундаас XX зууны эхэн хүртлэх үед арга зүйн институционал ба хэм хэмжээлэг хандлага хийгээд түүхийн ба харьцуулалтын арга; гуравдугаарт, 1920-иод оноос 1970-аад онд арга зүйн бихевиорист хандлага ба судалгааны тоон арга, дөрөвдүгээрт, дурдсан үеэс хойшхи буюу бихевиоризмын дараах үед судалгааны уламжлалт

арга зүй ба аргыг зарим шинэ хандлага, аргатай хослож хэрэглэх нь голлох болсон байна ( 9,27).

Улс төрийн онол нэг талаар гол үзэл санаа, үндэслэл, улс төр, нийгэм-соёлын шинж агуулга нь түүхэн цаг хугацааны тодорхой хэмжээст харьцангуй тогтвортой байх боловч нөгөөтэйгүүр улс төрийн амьдралын динамик өөрчлөлтийн нөлөө тусгалаар философи, ёс зүйн сургаал номлолтой харьцуулахад мэдэгдэхүйц өөрчлөгдөж шинэчлэгдэж байдаг динамик чанартай үзэгдэл ажээ. Улс төрийн онолын өөрчлөлт, хөгжилд нэг талаар түүний өөрийн нь дотоод өрнөлийн логик, нөгөөтэйгүүр улс төрийн амьдрал практик, түүхэн нөхцөл байдал, нийгэм-соёлын хүчин зүйлс нөлөөлдөг байна. Дотоод хүчин зүйлийн талаар гэвэл улс төрийн аль нэг үнэн зөв, хүч нөлөөтэй онол боловсрогдож цаашдын судалгаанд баримтлагдах явцад түүнээс хэд хэдэн үзэл баримтлал салбарлан гарч, яваандаа бие даасан урсгал чиглэлтэй онол болж хөгжөөд эхний онолд эргэж эерэг, сөрөг байдлаар нөлөөлдөг тохиолдол цөөнгүй гардаг жишээтэй. Улс төрийн онол нь нийгмийн амьдрал, улс төрийн практикаар няцаагддагийн нэгэн жишээ болгож капитализм нь социализмаар зайлашгүй халагдаж хувийн өмчгүй, нийгэм нийтийн өмчинд суурилсан, ангигүй нийгэм байгуулагдах, түүний алс хэтийн дээд шат болох коммунизмын үед төр мөхөх тухай зэрэг үзэл санааг агуулсан улс төрийн марксист – ленинист онолыг дурдаж болно. Улс төрийн онолын хөгжил, өөрчлөлт, нийгэм дэх бодит статус, үүрэг нөлөөний төлөв байдалд улс төрийн бодлого, нам, төр засгийн үзэл суртлын үйл ажиллагаа ихээхэн нөлөөтэй болно. Тэдгээрийн хүч нөлөөгөөр үндэслэлтэй, зөв зүйтэй онолыг үгүйсгэх, хавчин шахах, хоосон шүүмжилж элдэв муу нэр хаяг зүүх, эсвэл үүний эсрэгээр үндэслэлгүй, нийгмийн бодит амьдрал, практикт харшилсан, үзэл суртлын зорилго, шинж агуулга давамгайлсан онолыг шинжлэх ухаанч, үнэн зөв, шалгарсан гэх мэтээр хоосон магтаж зөвтгөх, нийгэмд хүчээр тулган хүлээлгэх явдлын аль аль нь ялангуяа ХХ зуунд дэлхийн нэлээд оронд тохиолдон гарч байсан билээ.

### **Улс төрийн онолын гол чиглэлүүд**

Улс төрийн онолын үүсэл хөгжил, орчин үеийн гол чиглэл, авч үздэг үндсэн асуудлын талаар товч өгүүлье. Улс төрийн сэтгэлгээний түүхэнд онолын шинжтэй олон чухал үзэл санаа эртний үеэс боловсрогдоор иржээ. Тэр нь ялангуяа Никколо Макиавеллигээс (1469-1577) эхэлж цаашдаа Жан Боден (1530-1596), Жон Локк (1632-1704), Томас Гоббс (1588-1679), Шарль Луи де Монтескье (1689-1775), Жан Жак Руссо (1712-1778), Иеремия Бентам (1748-1832), Жон Стюарт Милль (1806-1873), Алексис де Токвиль (1805-1859), Г.В.Ф.Гегель (1770-1831) зэрэг агуу их сэтгэгчдийн бүтээл туурвилаар хөгжин гүнзгийрч, улс төрийн онол XIX зуунд жинхэнэ утга агуулгаар үндэслэн боловсрогдох урьдач нөхцөл, хөрс суурийг бэлтгэн бий болгожээ. Тэдгээрийн үндсэн дээр боловсрогдож гарсан бүрэн гүйцэд, сонгодог хэлбэрийн улс төрийн онол бол К.Маркс (1818-1883), М.Вебер (1864-1920) нарын улс төрийн онол байв. Орчин үеийн улс төрийн янз бүрийн урсгал чиглэлтэй онол үндсэндээ чухам эдгээр онолд суурилж байна гэж оросын нэр эрдэмтэн Т.А.Алексеева бичжээ (7,26). Тиймээс эхлээд эдгээр онолын тухай товч өгүүлье.

К.Марксын нийгмийн сургаал, улс төрийн онол үүсэн боловсрогдоход францын нийгэм-улс төрийн сэтгэлгээ, английн улс төрийн эдийн засгийн ухаан, германы сонгодог философи үзэл санааны урьдач нөхцөл болж нөлөөлсний дотор Гегелийн философийн систем, диалектик арга ихээхэн үүрэг гүйцэтгэжээ. Гегель байгаль, нийгмийн бодит байдлын уг үндэс бол оюун санаа мөн, тэр нь биелэн илэрэх, хөгжих гурван үе шат, төлөв байдлыг дамжина. Эхний буюу

өөрийн хувийн дэвсгэр суурин дээр цэвэр сэтгэхүй буюу логикийн хэлбэрээр оршино, хоёр дахь шатад байгаль, гурав дахь шатад хүн төрлөхтөний түүх, оюун санааны түүх болж илэрнэ гэж үзээд түүнийг философийн системийнхээ оюун санааны философи гэсэн хэсэгт, бүр тодруулбал объектив оюун санааны хүрээнд авч үзжээ. Гегель улс төр, эрх зүйн сургаалдаа иргэний нийгэм, түүний бүтэц, бүрэлдэхүүн хэсэг, төр, түүний мөн чанар, үүрэг, зорилго, төрийн засаглал, түүнийг хуваарилах, дайн ба энх, тэдгээр нь улс төрийн үзэгдэл болох нь, дэлхийн түүх гэсэн томоохон асуудлуудыг шинжилжээ.

К.Марксын улс төрийн онол түүний хийсэн нийгэм, эдийн засгийн сонгодог шинжилгээний салшгүй чухал бүрдэл хэсэг, гол үр дүн болж, асар их эмпирик баримт материал, урьд өмнө хэрэгжиж байгаагүй гэж хэлж болох шинжлэх ухааны үндэстэй боловсруулж зорилго чиглэлтэй, чадварлаг хэрэглэсэн диалектик аргуудын үндсэн дээр боловсрогдож, олон бүтээлд нь томъёологдон бичигдсэн байна. Маркс улс төрийн онолдоо төр, улс төрийн бодлого, засаглал, дарангуйлал, тэдгээрийн гарал үүсэл, нийгэм-эдийн засгийн мөн чанар, үүрэг зорилго, түүнчлэн эрх, эрх чөлөө, шударга ёс, тэгш байдал, анги, ангийн тэмцэл, хувьсгал, тэдгээрийг хэрэгжүүлэх арга зам, хэрэгсэл зэрэг өргөн хүрээтэй чухал асуудлуудыг авч үзэж шинжилжээ. Марксын улс төрийн онол түүний социализм, коммунизмын тухай сургаалаас урган гарсан байна. Капитализм бол мөлжигч хөрөнгөтөн анги үйлдвэрлэлийн хэрэгсэлийг хувьдаа өмчилж өмчгүй ажилчин ангийг эдийн засгийн талаар мөлжсөн, бүхэлдээ нийгмийн дарлал, улс төрийн дарангуйлал, оюун санааны боолчлолд үндэслэсэн шударга бус, мөлжигч нийгэм учираас түүнийг пролетарийн хувьсгалаар халж, оронд нь хувийн өмч, дарлал мөлжлөггүй коммунист нийгмийг цогцлоон байгуулах зайлашгүй шаардлагатай гэж К.Маркс үзээд түүнийг эдийн засаг, улс төр, нийгмийн болон соёл-оюун санааны талаас нь судлаж, шинжлэх ухааны үүднээс үндэслэн нотлох зорилт тавьжээ.

Марксын дараах болон орчин үеийн улс төрийн онолууд үндсэндээ энэхүү агуу их сэтгэгч эрдэмтний онол, сургаалын эргэн тойронд үүсэн боловсрогдож, түүнийг талархан дэмжих, шинэ байдлаар эргэн харж шинэчлэх, шүүмжлэх зэргээр хандаж, нөлөө уламжлалыг нь ямар нэг байдлаар тусгасаар байгааг эрдэмтэн судлагчид зааж тэмдэглэж байна.

Улс төрийн онол нийгмийн амьдрал, практикт ямар нэг хэмжээгээр баримтлагдаж хэрэгжих, нөгөөтэйгүүр эс тэгсэн ч гэсэн онолын сэтгэлгээний өв сан, ололт, нийгэм-соёл, оюун санааны үзэгдэл болохын хувьд өөрийн дотоод логик, оршин үйлчилэхүйн өрнөлөөр цааш үргэлжилж уламжлагдах хоёр нь өөр өөр үзэгдэл, үйл явц болохыг ялган салгаж ойлгох, практик дээр ч тийнхүү хандах ёстой ажээ. Гэтэл манай оронд марксист сургаал, түүний улс төрийн онолд зөвхөн практикийн үүднээс хандаж, эл онол социалист байгуулалтай хамт түүхийн тавцангаас бүрмөсөн халагдаж, оюуны үнэ цэнэгүй болсон мэтээр үзэж байгаа нь тун өрөөсгөл хэрэг юм.

Марксист сэтгэлгээ тодорхой чиглэл, хувилбараар одоо ч гэсэн оршиж, орчин үеийн улс төрийн онолын сан хөмрөгт зохих байр суурь эзэлж байгаа билээ. Энэ бол тусгайлан авч үзвэл зохих том асуудал бөгөөд энд түүнийг дэлгэн өгүүлэх боломжгүй тул дараахь зүйлийг товч дурдаж хязгаарлагдья.

Марксын дараа түүний сургаал, онолыг нэг талаар ортодокс марксистууд зарим үзэл санаа, дүгнэлт нэмэрлэн үргэлжлүүлсэн боловч ЗХУКН зэрэг улс төрийн нам, хүчин түүнийг практикаас тасарсан догм болгож хувиргасанаар нэр хүндийг нь унагаасан бол нөгөөтэйгүүр Э.Бернштейн, К.Каутский нарын сэтгэгчид дутагдал, сул талыг нь олж харж, зүй ёсоор шүүмжилж эргэн харсан

байна. XX зуунд марксист сэтгэлгээ, түүний улс төрийн онолын хөгжилд шинэлэг чухал хувь нэмэр оруулсан сэтгэгчдийн тоонд Антонио Грамши, Никос Пуланзас, шинэ марксизмын шүүмжлэлт онолын төлөөлөгчдийг юуны өмнө оруулдаг.

Грамши (1891-1937, италийн сэтгэгч, коммунист) философи, нийгэм-улс төрийн үзэл санаагаа шоронд байхдаа бичсэн “Шоронгийн дэвтэрүүд” гэсэн нийт 7 боть алдарт бүтээлдээ тусган илэрхийлжээ. Грамши нийгэм, улс төрийн амьдралд хүний субъектив чанар буюу ухамсар, үзэл санаа ихээхэн үүрэгтэй болох тухай марксизмын үндэслэлийг уг ёсоор нь сэргээж тодруулах, бүтээлчээр баяжуулахад анхаарлаа голлон хандуулж чухал санаа бодлуудыг хэлжээ. Тэрбээр энэ дагуу марксизмын нэгэн ноцтой сул тал болох экономизм буюу нийгмийн амьдралыг эдийн засгийн үзлээр голлон тайлбарласаныг шүүмжилж эл хандлага нь улс төрийн үзэгдэл, үйл явц, түүний дотор ангийн тэмцлийн нарийн нийлмэл чанар, түүнчлэн фашист дэглэм үүсэж тогтсон зэрэг шинэ үзэгдлийг үнэн зөв танин мэдэж ойлгох бололцоо олгохгүй байгааг заасан байна. Үйлдвэрлэлийн хэрэгслийг өмчлөх хувийн өмч нь капиталист ноёрхлын чухал үндэс мөн боловч уг ноёрхлын бүрэн хүрэлцээтэй, тодорхойлогч үндэслэл хараахан биш, тиймээс эл асуудалд нийгэм-соёл, үзэл суртал, бусад субъектив хүчин зүйлийн үүднээс ч хандах хэрэгтэй гэжээ. Нийгэмд аль нэг анги төр барьж засаглан захирах нь албадан ноёрхох, хошуучлан манлайлах гэсэн хоёр талтай болно. Хошуучлан манлайлна гэдэг бол захирагдан буй ангийг соёл, үзэл суртлын арга хэрэгслээр дуулгавартай, эвлэрэнгүй болгоно гэсэн үг юм. Грамши төр, засаглалыг өргөн утга агуулгаар авч үзэж тэдгээр нь боловсрол, мэдээллийн хэрэгсэл, парламент, шүүх зэрэг нийгмийн институтууд болон эрх баригч ангийн манлайлал, идэвх санаачилгаар дамжиж хэрэгжинэ гэжээ. Төрийн үүрэг, байр суурь ирээдүйд улам өсөх бөгөөд тэр нь нийгэмд өмч хөрөнгийн төлөө байнгын ширүүн тэмцэл явагддагийн нэгэн адилаар хүмүүсийн үзэл санаа, ухамсрын төлөө ч байнга шургуу тэмцэх шаардлагатай байдагтай нягт холбоотой ажээ. Улс төрийн тэмцэл, үйл явдалд эрдэм боловсролтой сэхээтнүүд улам бүр өсөн нэмэгдэх үүрэг гүйцэтгэх болно. Учир нь нийгэм, улс төрийн амьдралын зохион байгуулалт, улс төрийн аливаа байгууллага, түүний үр нөлөөтэй үйл ажиллагаа, амжилт ялалт нь оюун сэтгэхүйн хүч чадалтай сэхээтэнгүйгээр бүтэж хэрэгжих аргагүй. Нийгэм, улс төрийн амьдралд онол чухал үүрэгтэй бөгөөд гэхдээ тэрээр хийсвэр, дедуктив сэтгэлгээний үр дүн биш, харин нийгмийн бодит амьдрал, улс төрийн амьд практиктай нягт харилцаа холбоотойгоор урган гарч боловсрогдох ёстой. Грамши тийнхүү субъектив хүчин зүйлийн тухай марксизмын үзэл санааг сэргээн босгож түүнийг XX зууны эхний гучаад жилийн нийгэм, эдийн засаг, улс төрийн амьдралыг шинжлэн дүгнэхэд амжилттай хэрэглэж чадсан улс төрийн томоохон сэтгэгч болно.

XX зууны 60-70 –аад онд бүтээн туурвиж марксист улс төрийн сэтгэлгээнд жинтэй хувь нэмэр оруулсан онолч бол Никос Пуланзас (1936-1980, грекийн эрдэмтэн, францын их сургуулиудад багшилж байв) юм. Тэрбээр “Засаг ба нийгмийн ангиуд” (1974), ялангуяа “Төрийн засаглал ба социализм” (1978) гэсэн нэрд гарсан бүтээлдээ капитализм, төр, төрийн засаглал, ангийн тэмцэл, хүчирхийлэл, нийгмийн хөдөлгөөн, социализм ба ардчиллын асуудлыг улс төрийн онолын түвшинд авч үзэж шинэлэг содон үзэл санааг гарган тавьсан байна. Капиталист төр бол хэрэг дээрээ засгийн эрх барьсан хөрөнгөтөн ангийн төр мөн бөгөөд түүний эрх ашгийг удаан хугацаагаар хамгаалж тогтвортой оршихын тулд уг хөрөнгөтөн ангиас тодорхой хэмжээгээр зай барихын хамт нийгмийн бусад ангийг төрийн удирдлагад оролцуулах хэрэгтэй болно.

Капиталист төр хэрэв аль нэг ангийг төрийн удирдлагаас шахан гаргах юм бол тэрээр өөрийн ангийн шинж чанараа нууж халхлах аргагүй байдалд орно. Капиталист төр тийнхүү удирдлагад нийгмийн анги бүлгүүдийг ямар нэг хэмжээ, хэлбэрээр оролцуулж байж өөрийгөө нийт нийгмийн эрх ашгийг илэрхийлэн хамгаалж байна, бүх ард түмний сайн сайхан, ашиг тусын тулд оршиж байна гэж ухуулан тунхаглаж, өөрийгөө бататгаж чадна. Капиталист төр хөрөнгөтөн ангийн манлайллыг хамгаалан хэрэгжүүлэх явцад ноёрхогч ба захирагдагч ангиудын хоорондын олон янзын харилцан буулт, зөвшилцөлийн тэнцвэрт бус харьцаанд оршиж түүнийг зохицуулахын тулд мөн олон янзын арга хэмжээ авдаг нь олон нийтэд ашиг тустай байдаг.

Капитализм “нэг хүн-нэг санал” гэсэн ардчиллын үзэл санааг дэмжсэнээр ангийн тэмцлийг эдийн засгийн хүрээнээс улс төрийн хүрээнд нэвтрүүлсэн гэж Пуланзас үзсэн бөгөөд хожмын бүтээлүүддээ эл үзлээ эргэн харж, ангийг бүрдүүлдэг хувь хүмүүс нийгэм, улс төрийн хөгжлийн явцад хоорондоо тусгаар шинжтэй эрх зүйн субъектууд болж хувирснаар ангиудын хоорондын мөргөлдөөн намжих болсон гэжээ. Энэ нь капиталист төр өөрийн ангийн шинж чанараа өнгөлөн далдахад тус болсон байхад харин ард олон дотроо задрахад нөлөөлжээ. Пуланзас хөрөнгөтний хууль, эрх зүй нь залхаан цээрлүүллийн элементийг тодорхой хэмжээгээр агуулдаг, хууль бол нийтийг хамарсан зохион байгуулалттай хүчирхийлэл юм гэжээ.

Пуланзас ХХ зууны хоёр дахь хагасын үеийн капиталист нийгэм болон төр, ангийн харилцаа, нийгмийн шинэ хөдөлгөөн, хүчнүүдийн хувьсал хөгжлийг судлан шинжилгээд ортодокс марксизмаас аажмаар хөндийрч еврокоммунизмд шилжжээ. Тухайлбал ангийн тэмцэл социализмд хүрэн баталгаатай арга хэрэгсэл биш болсон, капиталист нийгэмд феминист болон бусад хөдөлгөөн, хүчнүүд бий болж тэмцэл явуулах болсон явдал капиталист нийгэм сүрхий хувьсан өөрчлөгдөхөд хүргэж байгааг авч үзжээ. Сэтгэгч үүний зэрэгцээ тухайн үеийн ЗХУ болон бусад орон дахь социалист нийгэмд шүүмжлэлтэй хандаж социализм, ажилчин ангийн нам ардчилагдах ёстой гэж үзэж байв. Тэрбээр “социализм нэг бол ардчилагдах ёстой, эс тэгвээс ерөөс байхгүй болно” гэжээ. Энэ үзэл санаа түүний улс төрийн гэрээслэл, захиас болж үлджээ.

ХХ зууны марксист улс төрийн сэтгэлгээний хувьсал, хөгжилд шинэ **марксизмын (неомарксизм) шүүмжлэлт онол** буюу Франкфуртын дэг сургуулийн эрдэмтэн сэтгэгчид чухал хувь нэмэр оруулсан байна. Түүний гол төлөөлөгчид нь М.Хоркхаймер, Т.Адорно, Г.Маркузе, Э.Фромм, Ю.Хабермас, Ф.Поллок нар болно. Тэд шинэ марксизмын шүүмжлэлт үзэл санааг нийтлэгээр баримталсны хамт тус бүрийн нь зохиол бүтээлийн агуулга, үзэл баримтлал нь тодорхой хэмжээний ялгаа, онцлогтой ажээ. Тухайлбал Ю.Хабермас нийгмийн философич бөгөөд тэрбээр 1960-аад онд тухайн үеийн хөрөнгөтний нийгэм нь нийгэм-соёлын гүнзгий хямралтай байгааг зааж түүнээс гарах гол гарц, арга зам бол хүмүүсийн хооронд тогтсон гаж “хуурамч” харилцаа холбоог (интеракция, коммуникация) өөрчлөн халж, оронд нь хүнлэг, жинхэнэ утга агуулгатай харилцаа холбоог тогтоох явдал болохыг голлон авч үзжээ.

Марксист онол коммунизмын тухай сургаалыг үндэслэн боловсруулах явдлыг капитализмыг шүүмжлэн шинжлэх алхмаар эхэлсэн бөгөөд шинэ марксистууд энэхүү уламжлал буюу судалгааны шүүмжлэлт арга зүйг хадгалан баримталжээ. Тиймээс ч тэдний онол “шүүмжлэлт онол” гэж нэрлэгдэх болсон байна. Шүүмжлэлт онолынхон тухайн үеийн капиталист нийгмийн амьдралын янз бүрийн тал, төлөв байдлыг шүүн шинжлэхийг гол зорилт болгож түүнийгээ марксизмын дутагдал, сул тал, түүхэн хязгаарлагдмал шинжийг шүүмжлэн авч

үзэх алхмаар эхэлжээ. Тэд марксизмын ноцтой, гол дутагдал бол эдийн засгийн детеминизм, механик үзэл болохыг шүүмжлэн гаргажээ. Сэтгэгчид тэр дагуу марксизмын гол гол үзэл санаа, үндэслэлүүдийн хоорондын тэнцвэртэй харьцааг сэргээн тогтоох ёстой бөгөөд үүний тулд марксизмд зохих байр суурь эзлээгүй ирсэн нийгмийн амьдралын соёл, оюун санааны асуудалд илүү их анхаарал хандуулж шинжлэх хэрэгтэй гэж үзсэн байна. Тэдний судалгаа онолын асуудлын зэрэгцээ марксист онолыг удирдлага болгож байгуулагдсан ЗХУ дахь социалист байгуулалтын практикийг ч шүүмжлэн авч үзэхэд чиглэгджээ.

Шүүмжлэлт онолын төлөвшилд Макс Веберийн социологийн сургаал, тухайлбал рациоанл чанарын тухай үзэл баримтлал багагүй нөлөөлжээ. М.Вебер рационал чанар нь формал ба субстантив гэсэн хоёр хэлбэртэй гэж заасныг шүүмжлэлт онолынхон хүлээн авч, түүнд тодотгол тайлбар хийж формал хэлбэртэй рациональ чанар нь зорилгод хүрэх үр ашигтай арга хэрэгслийг сонгож хэрэглэх үйл ажиллагаа бөгөөд тэр нь техник, түүний арга хэрэгсэлийг шүтсэн технократ сэтгэхүйд үндэслэдэг, гэтэл эл сэтгэхүй нь нийгэм, хүмүүсийг ноёрхох зорилго тавьдаг, оюун ухаан, хүмүүнлэг ёсонд харшилдаг гэж үзжээ. Тэд нацизм ба түүний байгуулж хэрэглэсэн бөөнөөр хорих лагерь бол чухамдаа формал хэлбэрийн рационал чанарын хэрэгжилтийн тод илэрэл мөн, тухайлбал Освенцим нь рационал чанартай, үр ашигтай, гэвч оюун ухаанд харш, хүний санаа бодолд багтамгүй байр сав мөн гэжээ.

Шүүмжлэлт онолчдын дотроос Герберт Маркузе дээрхи үзэл санааг түлхүү баримталж орчин үе, орчин үеийн нийгэм, хүний амьдрал нь гадна тал, хэлбэрийн хувьд рационал чанартай байгаа мэт боловч мөн чанартаа иррационал, оюун ухаанд харш шинжтэй байна. Өөрөөр хэлбэл формал хэлбэрийн рационал чанар бол чин үнэндээ иррационал чанар юм. Үүний тод жишээ бүхий илэрэл бол орчин үеийн техник, түүний дотор мэдээлэл, харилцаа холбооны техник хэрэгсэл мөн болно. Тухайлбал телевиз нь хүмүүсийг нийгэмшүүлэн төлөвшүүлэхэд тус биш, харин хор уршиг учруулж байна, бүхэлдээ орчин үеийн техник хэрэгсэл хүмүүсийг үйл олноор нь үр нөлөөтэй, хялбар арга замаар хянаж жолоодох, үзэл ухамсарыг нь залж хууран мэхлэх, тэгснээрээ бие хүнийг эвдэж бэртээхэд хүргэж байна гэж шүүмжилжээ. Маркузегийн эдгээр шүүмжлэлт шинжилгээний үр дүн, дүгнэлт нь түүний “Нэг хэмжээст хүн” (оросоор “Одномерный человек”) гэсэн зохиолд томьёологдон бичигджээ.

Товч хэлбэл Франкфуртын дэг сургуулийн эрдэмтэд өнөөгийн хүн ард нь үзэл суртлын мунхруулга, эдийн засаг, нийгмийн боолчлол ноёрхон тогтсон орчин үеийн нөхцөл байдлаас яаж ангижирч, соён гэгээрүүлэлт, эрх чөлөөнд хэрхэн яаж шилжин орох вэ гэсэн асуулт тавьж, түүний хариуд үүний тулд хүмүүс ертөнцөд итгэж найдсан итгэл үнэмшил, үзэл бодлоо эргэн харж шүүн тунгаах хэрэгтэй, өөрөөр хэлбэл бидний аж төрж буй нийгэм ямар байна вэ, бид өөрсдөө хэн байна вэ гэдгийг шүүмжлэлт сэтгэлгээгээр тодруулан тогтоох хэрэгтэй гэсэн үзэл санааг гаргаж тавьсан байна.

Улс төрийн онолын сэтгэлгээний түүхэнд германы агуу их социологч, улс төрийн сэтгэгч **Макс Веберийн онол** чухал байр суурь эзэлнэ. Вебер Марксын зохиол бүтээлийг төдийлөн сайн судлаагүй, түүний улс төрийн онолын үзэл санаа, агуулгыг дараагийн үеийн марксистуудын үзэл баримтлалын жишээ тусгалаар төсөөлөн ойлгож байсан ч гэсэн түүний нөлөө багагүй байжээ. Гэвч Вебер Марксын улс төрийн онол эдийн засгийн детерминист үзэл, арга зүйд суурилсан, тухайлбал улс төр, түүний үзэгдэл, үйл явцууд эдийн засгийн амьдралаар нөхцөлдөж тодорхойлогддог гэж үзсэнийг шүүмжилж өөрийн

социологийн сургаал, улс төрийн онолоо Марксын онолын эсрэгээр тавьж боловсруулжээ. Веберийн социологийн сургаал ёсоор нийгэм, эдийн засгийн амьдралд үзэл санаа ихээхэн нөлөө үзүүлнэ.

Вебер социологийн арга хандлагаар улс төрийн өвөрмөц онол боловсруулсан бөгөөд түүний гол асуудал болгож ноёрхол, түүний түүхэн хэв маяг, тэдгээрээс урган гарч салаалдаг төр, улс төрийн бодлого, засаг, хүчирхийлэл, бюрократ ёс, түүний рационал чанар, улс төрийн нам, парламентын ардчилал, мэргэжлийн улс төрч, улс төр ба сэтгүүл зүй, улс төрийн ёс зүйн асуудлыг авч үзжээ. Вебер улс төр бол засаглалд оролцох, засаглалыг хуваарилахад нөлөөлөх эрмэлзэл мөн, төр бол тодорхой салбарын дотор хууль ёсны биет хүчирхийллийн онц эрхийг горилогч хүмүүсийн холбоо, бас үүндээ хэрэглэх хэрэгсэлийн үүднээс хандвал хууль ёсны хүчирхийлэлд тулгуурласан хүмүүс нь бусад хүмүүсийг ноёрхох харилцаа юм гэж үзжээ. Нийгэмд ноёрхлыг зөвтгөж хууль ёсны болгодог гурван янзын дотоод зөвтгөл буюу үндэслэгээ байдаг нь нэгд, нэр хүнд, хоёрт, ноёрхогчийн хувийн ер бусын авьяас, увдис бүхий харизм, гуравт, хууль ёс, эрх зүй ажээ. Эдгээрийн үндсэн дээр ноёрхлын гурван том “цэвэр” хэв маяг бий болдог бөгөөд тэдгээр нь уламжлалт ноёрхол, харизматик буюу бишрүүлэгч ноёрхол, хуулиар зөвшөөрөгдсөн ил ноёрхол мөн болно. Веберийн улс төрийн онолын нэгэн чухал үзэл санаа бол улс төр мэргэжил болох тухай, өөрөөр хэлбэл мэргэжлийн улс төрчид хийдэг бюрократ ёсны тухай юм. Веберийн улс төрийн онол дараагийн онол сургаалиудад багагүй нөлөөлжээ.

Орчин үеийн улс төрийн онолын нэгэн өвөрмөц чиглэл бол хүний уг чанар нь (природа человека) улс төр, улс төрийн байгуулал, дэглэм, хувьсгалд нөлөөлдөг үү, эдгээр нь хоорондоо холбоо хамааралтай юу гэсэн чухал асуудлыг судлагдахуун болгосон онол юм. Түүний гол төлөөлөгчид бол Э.Фромм (1900-1980), Г.Маркузе (1898-1979) нар болно. Францын экзистенциалист философич Жан-Поль Сартрын (1905-1980) хүний уг чанарын тухай үзэл санаа улс төрийн энэхүү онолд тодорхой хэмжээгээр холбоотой.

Э.Фромм, Г.Маркузе нарын улс төрийн үзэл санаанд З.Фрейдийн сэтгэцийн шинжилгээ багагүй нөлөөлжээ. Хүний уг чанарт түрэмгий зан, хатуу хахир зан авир угаас зуршмал байдаг бөгөөд тэр нь нийгэмд илэрэн гарах байнгын боломжтой учираас төр засаг, улс оронд хуулийн дэг журам сахиулах үүргээ чанд биелүүлэх ёстой гэж З.Фрейд үзжээ. Түүний эл үзэл санаа улс төрийн онолд мэдэгдэхүйц нөлөөлжээ. Түүний үр дүнд улс төрийн онол нийгмийн сайн сайхан, буян, ёс суртахууны ойлголт, хэм хэмжээний тухай номлох нь багасч улс төрийн судалгаанд “хэрэгцээ”, “сэдэл түлхэц”, “сэтгэцийн эрүүл мэнд”, “невроз” (сэтгэл мэдрэлийн гажиг), “паталог” (эмгэг судлал) гэх мэт ойлголт, нэр томъёог хэрэглэх болсноор улс төрийн хэл зүйд шинэ өөрчлөлт гарснаар барахгүй улс төрийн онол өөрөө бүхэлдээ нийгмийн амьдрал хэвийн, эрүүл байгаа эсэхэд онош тавих болсон байна.

Э.Фромм хүний түрэмгий зан чанар, бусад сөрөг шинж, гажуу үйлдэл нь төрөлхийн биш, харин тухайн нийгмийн гажуудал, хэвийн бус байдлын үр дагавар, тусгал болж илэрэн гардаг гэж үзжээ. Фромм, нийгэм ба түүний улс төрийн систем нь хүний бүтээлч хүч нөөцийг нээж хэрэгжүүлэх нөхцөл бололцоог хангах ёстой, хүн аз жаргал, эв зохирол, хайр энэрэл, эрх чөлөөг эрхэмлэж тэмүүлсэн байдаг, гэтэл капиталист нийгэм үүнд нь саад болдог, хүнийг хүнийсгэдэг. Тиймээс либерализмд үндэслэсэн капитализмыг бүх талаар нь, түүний дотор улс төрийн амьдралыг нь шинэтгэн өөрчилж “эрүүл”, хэвийн болгох хэрэгтэй гэсэн үзэл санааг гарган тавьжээ.



Маркузегийн улс төрийн үзэл санаа түүний боловсруулсан “нийгмийн шүүмжлэлт онол”-д тусаж илэрчээ. Тэрбээр Фроммын нэгэн адил хүний шинж чанарын гажуудал нь хэвийн бус, эрүүл бус нийгэм ба түүнийг төр засаг хэрээс хэтэрсэн цээрлэл, шийтгэлээр засаж эрүүлжүүлэх гэсэн оролдлогын улмаас бий болдог гэж үзсэн байна. Нийгэм дэх цээрлэл, шийтгэл нь байвал зохих, хэвийн ба илүүдсэн гэсэн хоёр хэв маягтай байдаг. Эхнийх нь улс төрийн зохион байгуулалттай нийгэмд хуулийн дэг журам сахиулах зайлашгүй хэрэгцээ шаардлагаар оршиж үйлчилнэ. Гэтэл капиталист нийгэм, түүний улс төрийн байгуулал нь хуулийн дэг журам сахиулах хэрэгцээ, хэр хэмжээнээс давж хэтэрсэн, илүүдсэн цээрлэл хэрэглэж байгааг арилгах хэрэгтэй. Түүнийг чухам тэрхүү капиталист байгуулал, ангийн ноёрхолыг хувьсгалаар халж оронд нь шинэ нийгэм байгуулах замаар л хэрэгжүүлж болно гэж Маркузе үзжээ. Тэгэхдээ сэтгэгч эл үзэлдээ тодорхой хэмжээний зарим засвар, тодотгол оруулж байв.

1930 – аад оны үед Фромм М.Хоркхаймертай хамтран хүний шинж чанар ба улс төрийн дэглэмийн холбоо хамаарлыг “авторитари бие хүн” гэсэн сэдвээр судлаж зарим үр дүнг нийтлэж байсныг Франкфуртын дэг сургуулийн Теодор Адорно тэргүүтэй төлөөлөгч эрдэмтэд 1940-өөд онд сэргээн үргэлжлүүлсэн байна. Энэхүү хамтын судалгааны үр дүнд ихэнх хэсгийг нь Т.Адорно бичиж бэлтгэсэн “Авторитар бие хүн” гэсэн бүтээл 1950 онд хэвлэгдэн гарч эрдэмтэн судлагчид, улс төрчдийн анхаарлыг ихэд татаж цаашдын судалгааны эргэлтэд идэвхтэй оржээ. М.Хоркхаймер энэхүү судалгааг дүгнэн үнэлэхдээ эдгээр эрдэмтэд антропологийн нэгэн шинэ төрөл зүйл болох авторитари хэв шинжийн бие хүнийг илэрүүлэн тодорхойллоо, эл бие хүн зохих мэдлэг чадвар, боловсрол, бусад эерэг шинжтэйн зэрэгцээ иррационал, мухар санаатай, бусдын үйл байдал, үзэл санааг тэвчдэггүй, тэгсэн хэрнээ засаг төр, албан тушаалтны нэр хүндэд захирагдах дуртай зэрэг сөрөг, авторитар шинжтэй, чухам ийм бие хүмүүс фашист дэглэмийн нийгмийн бааз суурь болох боломжтой гэжээ.

Улс төрийн онолын судалгааны уламжлалт чиглэл бол төр, засгийн газар, парламент, улс төрийн систем, улс төрийн нам, олон нийтийн байгууллага, үндсэн хууль, орон нутгийн засаг захиргаа зэрэг улс төрийн байгууллагуудыг (институци) судалдаг **институционал хандлага** болно. Түүнд судалгааны түүхийн ба индуктив, формал ба легал, түүхэн харьцуулалтын арга хандлага голлон хэрэглэгддэг. Институционал хандлагын хүрээнд үндсэн хууль судлал, нийтийн захиргааны онол (нийгмийн удирдлага – public administration), зохион байгуулалтын онол харьцангуй бие дааж салбарлан гарсан байна.

Улс төрийн онолын судалгааны институционал хандлага ХХ зууны хэдэн арван жилд бихевиорализмын түрэлтээр нөлөө, чухал шинж нь суларч байсан боловч 1970-аад оноос дахин сэргэж, шинэчлэгдэн хөгжих болжээ. Түүний танин мэдэхүйн давуу чанар бол албан ёсоор зохион байгуулагдаж бүтэцжсэн, үйл ажиллагаа нь хуулиар зохицуулагдсан, нийгэм, улс төрийн амьдралд чухал үүрэг гүйцэтгэдэг улс төрийн байгууллага бүхий институтуудыг онолын түвшинд судлаж ойлгох бололцоо олгодогт оршино. Харин сул тал нь улс төрийн харилцаа, үйл явцын анхдагч нэгж, нэгэн зэрэг субъект ба объект болдог бие хүмүүсийн улс төрийн үйл байдлыг анхаарлын гадна үлдээдэгт байгаа билээ.

1950-иад оноос улс төрийн онолд чухал байр суурь эзлэн гарч ирж баримтлагдах болсон улс төрийн судалгааны чухал чиглэл бол **рационал сонголтын онол** юм. Эл онол арга зүйн индивидуализмд үндэслэдэг бөгөөд гол үзэл санаа нь нийгмийн үзэгдэл, үйл явц, түүний дотор улс төрийн үзэгдэлүүдийг хувь хүмүүс бүхий тусгаар бодгалуудын үйл байдлыг судлах

замаар танин мэдэж ойлгож болно, учир нь хүмүүс эдийн засгийн амьдралд оролцохдоо өөрсдийн материаллаг ашиг сонирхол, сайн сайхан амьдрах хэрэгцээ, зорилгоо гол болгож рационал буюу ухаалаг сонголт хийдэгтэй нэгэн адил улс төрд оролцохдоо ч тийнхүү зүй зохистой хандаж рационал сонголт хийдэг гэсэн үзэл баримтлал мөн болно. Рационал сонголтын онолыг профессор Ё.Довчин судалж байгаа бөгөөд түүний зарим үр дүнг өөрийн өгүүлүүддээ тусган өгүүлжээ (7).

Улс төрийн онолын уламжлалт томоохон чиглэл бол **норматив буюу хэм хэмжээлэг онол** билээ. Түүний гол салбар чиглэлүүд нь **утилитаризм, деонтологийн либерализм** (deontology – деонтология – грек хэлний деоу буюу үүрэг, байвал зохих зүйл гэсэн утгатай үгнээс гаралтай бөгөөд нэг үгээр хэлбэл үүргийн ёс зүй юм), **либертаризм, коммунитаризм** юм. Хэм хэмжээлэг онолын онцлог шинж бол түүний үзэл санаа, дүгнэлт, үнэлэлт нь нийгмийн байгуулал, түүний дотор нийгмийн амьдралын улс төрийн зохион байгуулалт ямар байвал зохих вэ гэдгийг зааж зөвлөсөн, нийгэм, улс төрийн практикт хандсан шинжтэй байдаг оршино. Эл онол нийгэм, нийтийн сайн сайхан байдал, буян, шударга ёс, тэгш байдал, үүрэг, хариуцлага зэрэг ёс суртахууны хийсвэр ойлголтуудыг хэрэглэж сэтгэдэг, гэхдээ түүнийгээ улс төрийн бодит практикт буулгаж амьдралд хэрэгжүүлэх талаархи тодорхой асуудлыг ч авч үздэг.

Хүмүүс олон янзын учир шалтгаан, нөхцөл байдал, хүчин зүйлийн эрхээр чухам нийгэмд, нэгэн дээвэр дор хамтран аж төрөх зайлашгүй шаардлагатай. Гэхдээ тэрхүү хамтын амьдралын хамгийн боловсронгуй хэлбэр болсон нийгэм нь мөн олон янзын шалтгаанаар заавал улс төрийн зохион байгуулалттай байх, өөрөөр хэлбэл нийгэм нь улс төрийн засаглалтай, бүр тодруулбал төрийн засаглалтай байх амин чухал хэрэгцээ шаардлагатай юм. Нийгэм нэгэнт тийм уг чанартай учираас түүнийг бүрдүүлдэг хүмүүсийн хамтын амьдралыг тэдний нийтлэг эрх ашигт нийцсэн түгээмэл зарчим, ерөнхий хэм хэмжээгээр эмхлэн зохицуулж, зүй зохистойгоор зохион байгуулах хэрэгтэй гэсэн улс төрийн философийн үндэслэл нь дээр дурдсан норматив онолуудын үзэл санааны ерөнхий үндэслэл болдог байна. Гэвч норматив онолын тодорхой чиглэлүүд энэхүү ерөнхий үзэл санаа, үндэслэлд харилцан ялгаатай байдлаар хандаж өөр өөрөөр тусгадаг талтай. Чухам үүгээрээ норматив онолын тодорхой урсгалууд хоорондоо онол, үзэл баримтлалын ихээхэн ялгаатай байдаг.

**Утилитаризм** (utilitas – латин хэлний ашиг гэсэн утгатай үгнээс гаралтай нэр томьёо) нь нийгмийн байгуулал, түүний улс төрийн зохион байгуулалтын зүй зохистой сайн хэлбэрийн хамгийн гол, тодорхойлогч шалгуур бүхий үндэслэл бол илүү олон хүнд хамгийн их ашиг тус олох боломж нөхцөлийг хангах явдал юм гэсэн үзэл санааг онолын үүднээс үндэслэж номлодог. Утилитаризмын гол зарчим, үзэл санаа олон зүйлээр либерализмтай зөрчилдөж харшилдаг.

Тэдгээрийн хоорондын онол, үзэл баримтлалын маргаан, мэтгэлцээний үр дүнд либерализмын нэгэн чухал урсгал болж деонтологийн либерализм боловсрогдон гарчээ. Түүнийг онолын үүднээс үндэслэн боловсруулсан сэтгэгч бол америкийн улс төрийн онолч эрдэмтэн Жон Роулз юм. Тэрбээр 1971 онд нийтлүүлсэн “Шударга ёсны онол” (Rawls J. A Theory of Justice. Harvard, 1971) гэсэн алдарт бүтээлдээ орчин үеийн зах зээлийн эдийн засгийн зарчимд үндэслэсэн нийгмийн шударга байгууллын тухай асуудлыг авч үзэж шинжилжээ. Түүний эл бүтээл улс төрийн философи, улс төрийн онолын аль алины шинж чанарыг агуулсан бөгөөд тиймээс улс төрийн судалгаа, мэдлэгийн эл хоёр салбар 1970-аад оноос дахин сэргэж идэвхжих гарааг эхлүүлсэн байна.

**Либертаризм** нь улс төрийн онолын уламжлалт том чиглэл болох либерализмын орчин үеийн урсгал болно. Түүний гол төлөөлөгчид нь Ф.Хайек, Р.Нозик нар юм. Либертаризм хувь хүмүүсийн эрх, эрх чөлөөг гол болгож эрхэмлэдэг бөгөөд нийгэм, эдийн засгийн амьдралд төрийн оролцоо хамгийн бага хэмжээтэй байх ёстой, учир нь төр бол ер нь хүмүүсийн эрх, эрх чөлөө, зах зээлийн эрх чөлөөг боож гажуудуулдаг гол хүч гэсэн ерөнхий үзэл санааг баримталдаг. Либеритаризм дотроо прагматик ба зарчмын либертаризм гэсэн хоёр урсгалтай. Прагматик либертаризмын гол зарчим, үзэл санааг Ф.Хайек үндэслэн боловсруулжээ. Эл урсгал нийгмийн болон улс төрийн хамгийн зүй зохистой байгуулал, зохион байгуулалтын хэлбэр нь хүмүүсийн эрх, эрх чөлөө, зах зээлийн эрх чөлөөг ихээр хангах, харин төрийн үүрэг, оролцоог боломжийн хүрээнд хамгийн бага байлгах явдалд үндэслэнэ, түүнчлэн нийтийн ашиг тус, сайн сайхныг үндэс болгож нийгмийн шударга ёсыг төрийн үүрэг оролцоогоор хангахыг оролдож огт болохгүй, тийм оролдлого хувь хүмүүсийн эрх, эрх чөлөө, зах зээлийн механизмыг эвддэг бол оюун санаагаар боловсруулан зохиосон ямар нэг загвар, аль нэг онолын дагуу нийгмийг өөрчлөн байгуулах, эдийн засгийг нийгэмчлэх нь эцсийн дүндээ тоталитаризмд хүргэнэ гэж үздэг. Энэхүү үзэл баримтлал Ф.Хайекийн “Боолчлогдох зам” зохиолд тод тусчээ.

Зарчмын либертаризм нь хувь хүмүүсийн эрх бол жам ёсны бөгөөд суурь чанартай, хөндлөнгийн ямар нэг нөхцөл, хүчин зүйлээр тодорхойлогддоггүй, өөрөө өөртөө эрхэм, дээд зэргийн үнэт чанартай зүйл бөгөөд түүнийг минимал буюу нийгэмд хамгийн бага оролцоотой төр (minimal stat – минимальное государство) хамгаалах ёстой гэсэн үзэл санааг баримталдаг. Эл урсгалын гол төлөөлөгч нь Роберт Нозик юм. Түүний онолын үзэл баримтлал 1974 онд нийтлэгдсэн “Анархи ёс, төр, утопи үзэл” гэсэн суурь бүтээлд томъёологдон бичигджээ. Нозик нийгэм, бүлгийн ямар нэг сайн санаат зорилго, эрх ашиг, нийтийн сайн сайхан, тэгш байдлыг эрхэм болгож хувь хүний эрхийг зөрчиж огт болохгүй. Төр бол хувь хүмүүс өөрсдийн эрх, нийгэм, эдийн засгийн зорилгоо хэрэгжүүлэх нөхцөл бололцоог хангаж хамгаалах, нийгмийг гэмт хэрэг, хэв журмын зөрчилгүй амгалан тайван байлгах үүргийг л гүйцэтгэх ёстой. Ийм төрийг минимал төр гэх ба тэрээр шударга, зүй зохистой, хүмүүсийн санаа сэтгэлд нийцтэй байх учираас ёс суртахууны хувьд хүлээн зөвшөөрөгднө. Хүмүүсийн хамтын амьдралын хэлбэр бүхий нийгмийг улс төрийн талаар сайн зохион байгуулах шалгарсан ганц хэлбэр, загвар, эсвэл төгс төгөлдөр ганц үзэл санаа гэж байдаггүй, байх ч аргагүй. Тиймээс хүмүүс минимал төрийн үзэл санааны хүрээнд хувийн эрх, эрх чөлөөгөө хохирохгүйгээр өөрсдийн хамтын амьдралаа зүй зохистой зохион байгуулах, түүндээ санаж бодсон, сонгосон хувилбараа хэрэгжүүлэхийг оролдох эрх чөлөөтэй байх ёстой. Нозик үүнийг утопи гэж нэрлээд утопи бол нийгмийн амьдралыг зохион байгуулах янз бүрийн утопи загваруудыг турших том тайз, тавцан юм гэжээ.

Нозик минимал төр нь төргүй нийгэм буюу анархизмаас ялгаатай болохыг өөрийн үзэл баримтлалын нэгэн чухал асуудал болгож авч үзсэн байна.

**Коммунитаризм** бол нийгмийн амьдралын зохион байгуулалтын зүй зохистой хэлбэр нь иргэний ёс суртахууны үнэт зүйл, гэр бүл, уламжлал, хамтач ёс, нийтийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн аюулгүй байдлыг эрхэмлэсэн зарчимд үндэслэсэн байвал зохих тухай асуудлыг гол болгож авч үздэг улс төрийн онолын чиглэл болно. Хэрэв эдгээр үнэт зүйл, асуудал хэрэгжиж шийдвэрлэгдвэл нийгмийн ёс суртахууны уур амьсгал, амьдралын нөхцөл байдал эерэгээр өөрчлөгдөх бөгөөд тэгснээр нийгмийн амьдрал дах төрийн оролцоо багасана, хүмүүсийн эрх, эрх чөлөө ба үүрэг, хариуцлагын хооронд зүй

зохистой тэнцвэрт харьцаа бий болно, эдгээр нь бүхэлдээ улс төрийн амьдралд авторитари хандлага, үйл явц бий болж лавшрахаас сэргийлэх ажээ.

Коммунитаризм хувь хүмүүсийн эрх, эрх чөлөө, хувиа бодох үзлийн тухай либерал үзэл баримтлалыг олон зүйлээр шүүмжилдэг. Шүүмжлэлийн гол үзэл санаа нь хувь хүмүүсийн эрх, эрх чөлөөний тухай либерал үзэл нийгмийн бодит амьдралаас хөндий, хийсвэр агуулгатай юм. Либерализмын дүрслэн гаргаж номлодог индивидуализм нь онолын үүднээс бол хүмүүсийн хоорондын нийгмийн харилцаа, хэлхээ холбоо эвдэрч, хувь хүмүүс бие биеэсээ хүнийссэн, уламжлал алдагдсан, нэг үгээр хэлбэл нийгмийн амьдрал хэвийн бус болсон нөхцөлд бий болж илэрэх боломжтой. Хувь хүн, түүний эрх, эрх чөлөө, тэдгээрийн хэрэгжилт нь нийгэм болон түүний хүрээн дэх тосгон, суурин газар, бичил соёл, угсаатны бүлэг, нийгэм-улс төрийн хөдөлгөөн, байгууллагын амьдрал, үйл ажиллагааны дотор бий болж хангагдан биелэх боломжтой байдаг. Тиймээс хувь хүн бүр нийтийн сайн сайхны төлөө чиглэсэн зорилт үүргийг биелүүлэхэд оролцох ёстой гэсэн үзэл санаа болно.

Коммунитаризмын гол төлөөлөгчид нь Майкл Сэндел, Майкл Уолцер, Чарльз Тейлор нар болно. Гэхдээ коммунитаризмын онолын баримтлал, үзэл санаа тэдний ямар нэг зохиол бүтээлд тодорхой, барьцтай агуулгаар, цэгцтэй томъёологдож бичигдээгүй, тэд үзэл санаагаа улс төрийн бусад онол сургаалыг шүүмжлэн авч үзэх явцад дам байдлаар илэрхийлсэн байдаг ажээ. Энэ нь коммунитаризмыг улс төрийн онолын бие даасан урсгал чиглэл болох үүднээс тодорхой судлан шинжлэхэд багагүй бэрхшээл үүсгэдэг байна.

**Консерватизм** нь улс төрийн онолын уламжлалт том чиглэл бөгөөд хувьсал хөгжлийн урт замыг туулжээ. Тэрээр нэг талаар улс төрийн онолын сэтгэлгээний хэвшин тогтсон, өөрийн уламжлалтай бүхэл бүтэн чиглэл болохын хувьд суурь чанартай ерөнхий үзэл санаа, үндэслэлд суурилдаг. Тэр нь нийгэм, улс төрийн байгуулал бол түүхийн жам ёсны, аажим алгуур үйл явцын бүтээгдэхүүн байдаг, тиймээс түүний өөрчлөлт, хөгжил нь нийгмийн субъектуудын хөндлөнгийн дур зоргын огцом оролцоогүйгээр, нэг үгээр хэлбэл хувьсгалаар биш, харин цагийн шалгуурыг давж хэвшин тогтсон нийгмийн болон улс төрийн институтууд, соёлын үнэт зүйлс, уламжлалыг хадгалж аажим хувьсах замаар явагдах ёстой гэсэн үзэл баримтлал болно. Түүнчлэн улс төрийн консерватив сэтгэлгээ ба үйл ажиллагаа, улс төрийн консерватив бодлогыг ерөнхийд нь нөхцөлдүүлж байдаг тогтож хэвшсэн хэд хэдэн үндэслэл бүхий баримтлал байда. Тэдгээр нь шашин бол нийгмийн дэг журмын баттай үндэс гэж үздэг; хүний уг шинж ба оюун ухаанд төдийлөн итгэдэггүй, сөрөг байдлаар ханддаг; нийгэм бол органик буюу жам ёсны чанартай, бас язгуур давхраа, анги бүлгийн хувьд буюу нийгмийн бүтэцээрээ шаталсан зэрэг зиндаа бүхий зохион байгуулалттай; улс төрийн засаглал ба шашин сүм хийдийг сүслэн хүндэтгэдэг; уламжлал, ёс заншилын үүрэг, ач холбогдолыг өндөрт тавьдаг; аливаа асуудал, зорилтыг нийт үндэстэн, ард түмний хэмжээнд тавьж ханддаг; улс төрийн практикт аливаа асуудлыг прагматик байр сууринаас, тодорхой хандаж, тогтож хэвшсэн арга хэрэгслээр шийдвэрлэдэг; төрийн гадаад бодлого, олон улсын харилцаанд их гүрний (империйн) дээрэнгүй байр суурь баримталдаг явдал болно.

Консерватизм нийгэм-түүхийн янз бүрийн эрин үед аж төрж, туурвин бүтээж байсан үе үеийн өөр өөр сэтгэгчдийн оюун сэтгэхүйгээр боловсрогдон хөгжиж ирсэний хувьд дотроо үзэл санааны ихээхэн ялгаа онцлогтой хэд хэдэн салбар онол бүхий урсгалтай юм. Тэдгээрийн заримыг товч дурдъя.

Консерватизмыг онолын үүднээс үндэслэсэн сэтгэгч бол Эдмунд Бёрк бөгөөд түүний гол бүтээл нь 1790 онд нийтлэгдсэн “Франц дахь хувьсгал ба эл

үйл явдалтай холбогдож Английн нийгэмд болж буй үйл явдлын тухай бодол эрэгцүүлэл” гэсэн зохиол билээ. Бёрк улс төрийн онолоо түүх, нийгэм ба уламжлалыг консерватив үзлээр авч үзэж тайлбарлах зарчимд үндэслэн боловсруулжээ. Хүн төрөлхтөн өөрийгөө зөвхөн түүхээр, түүхэн цагийн шалгуурыг давж хэвшин тогтсон нийгмийн болон улс төрийн байгууллаар илэрхийлэн харуулж чадна. Хүн угаасаа шинж чанар нь тогтворгүй, тодорхойгүй, бас хорон санаатай, мунхаг байдаг тул түүнийг тогтвортой, дэг журамтай, уламжлалаа хадгалсан нийгмийн байгууллаар дэглэн барьж байх хэрэгтэй болдог. Уламжлал бол урт хугацааны ёс заншил, мэргэн ухааны нийлбэр түүх бөгөөд нийгмийн шударга ёсыг тогтооход хэрэглэж болох найдвартай, ухаалаг хэрэгсэл юм. Нийгмийн улс төрийн амьдрал, байгуулал ч уламжлалыг даган баримтлах ёстой. Хэмжээ хязгааргүй эрх, эрх чөлөөнд тэмүүлсэн хувь хүний жолоогүй хувиа бодох ёс (индивидуализм) ба улс төрийн дарангуй, хэрцгий засгийн аль аль нь уламжлал, ёс заншлыг дур зоргоор зөрчиж эвдснээс үүсэж гардаг. Хэвшин тогтсон нийгэм, улс төрийн байгууллыг ямар нэг үзэл суртлын дагуу өөрчлөн хувиргахыг оролдох нь улс орноо цэвэр цагаан цаас гэж үзэн түүнд бодсон санаснаа эрээчин бичихтэй адил зүйл болно. Францын хувьсгал нийгмийн уламжлалт байгууллыг эвдэн нурааж байгаа нь ирээдүйд үүсэн гарах дээрэм, тонуул, эмх замбраагүй анархи байдлын үүрийг тарьж байгаа хэрэг бол, эл хувьсгалаар хүний эрх, эрх чөлөөг хийсвэр тунхаглаж байгаа нь ирээдүйд урсах цус, улс төрийн дарангуйлал, хэрцгийллийн гэрлэн дохио юм гэж Бёрк Францын хувьсгалыг үзэн яджээ. Тэрбээр “Францын хувьсгалчдын цэцэрлэгт хүрээлэнгийн (академийн) гудамж зам бүрийн эцэст цаазын дүүжлүүр харагдна” гэжээ.

Бёрк төр, парламент, засаглалын хэлбэр, үндсэн хууль, нийгэм, эрх, эрх чөлөө, ардчилал, шашны улс төрийн үүрэг нөлөө зэрэг олон үзэгдлийг консерватив үзэл баримтлалын үүднээс авч үзжээ. Түүний онолын баримтлал консерватив сэтгэлгээний цаашдын хөгжил, хувьсал, шинэ урсгал чиглэлүүдийн үүсэлд ихээхэн нөлөөлсөн байна.

Германы улс төрийн онолч Карл Шмитт (1888-1985) консерватизмын номлолыг шууд баримтлаагүй, түүгээр тухайлсан зохиол бүтээл бичээгүй ч гэсэн улс төрийн асуудлыг голлон авч үзсэн “Ромын католик шашин ба улс төрийн шинэтгэл” (1923), “Улс төрийн тухай үзэл баримтлал” (1932), “Левиафан” (1938, тэрбээр эл бүтээлдээ Томас Гобссын улс төрийн философийг шинжилжээ) гэсэн зохиолдоо либерализмын номлолыг ул үндэстэй шүүн шинжилж, сул тал, зөрчил дутагдалыг нь нарийн гаргаж тавьсан нь консерватизмын онолын хөгжил, ялангуяа Америк дахь консерватив сэтгэлгээний төлөвшил хөгжилд ихээхэн нөлөөлжээ. Шмиттыг авторитар хэлбэрийн этатист үзэл баримтлалыг (этатизм – төрийг шүтэх үзэл) үндэслэгч гэж үздэг.

Консерватив онолчид 1970-аад оны сүүлээр нийгэм, эдийн засаг, улс төр, соёл, шашны асуудлаархи уламжлалт үзэл баримтлалыг эргэн харж зарим талаар шинэчлэхийг оролдсны дагуу орчин үеийн консерватизм боловсрогдон гарсан байна. Түүнийг өөрсдийгөө Солсберийн бүлэг гэж нэрлэсэн социологич, улс төр судлагч хэсэг эрдэмтэн санаачлан боловсруулжээ. Эл урсгал Английн уламжлалт консерватизм өөрийгөө соёлын өв, уламжлалт аж төрөх ёс, шашин, ёс суртахууны үнэт зүйлс, байгаль орчин, эдийн засгийн монетари бодлогыг эрхэмлэн хамгаалагч гэж үздэгтэй нягт холбоотойгоор бий болжээ.

**Соёлын консерватизмын** төлөөлөгчид зөвхөн соёл биш, ер нь орчин үеийн консерватизмын онолын үндэсийг бүхэлд нь цэгцтэй авч үзэж илэрхийлэх

зорилт тавьж түүнийгээ 1979 онд нийтлүүлсэн анхны хамтын бүтээл болох “Консерватив эссе” гэсэн зохиолд тусгаж томъёолсны зэрэгцээ эл урсгалын гол онолч Роджер Скрутон консерватив онолын үндэс, гол асуудлуудыг авч үзсэн “Консерватизмын утга учир” (1980), “Декартаас Витгенштейн хүртэл” (1981), “Соёлын бодлого” (эссе, 1981), “Улс төрийн сэтгэлгээний толь бичиг” (1982) гэсэн бүтээлүүдийг гаргасан байна. Соёлын консерватизмын голлон анхаарч авч үзсэн чухал зүйл бол нийгэм, улс төрийн байгууллын тогтвортой байдал, оршин тогтнолын суурь үндэс нь соёл, ялангуяа “өндөр дээд соёл”-ын уламжлал мөн болох тухай асуудал болно.

Эл урсгалын үзэл баримтлал ёсоор нийгмийн янз бүрийн байгууллага болон практик нь хүмүүсийн хоорондын харилцаа, хэлхээ холбоог ханган тогтоож байдаг бөгөөд тэдгээрт нийгмийн ерөнхий соёл ихээхэн нөлөө үүрэгтэй. Уг соёл бүхэлдээ хувь хүмүүсийн амьдралыг утга учиртай болгож, хувийн туршлагыг нь бататгаж байдаг. Төр бол нийгмийн эрхэм дээд ерөнхий соёлын илэрхийлэл, биежилт байдаг учираас уг соёлыг гадаад дотоодын дайснаас хамгаалж бататгах үүрэгтэй. Нийгэмд тэгш бус байдал, язгуур, давхрааны зэрэг зиндаа, шатлал оршин байдаг нь жам ёсны үзэгдэл бөгөөд түүнийг консерватив үнэт зүйлс тусган илэрхийлдэг нь мөн зүй ёсны хэрэг ажээ.

Соёлын консерватизм ер нь нийт, уламжлалт консерватизмын нэгэн адилаар оюун ухаан, онолын сэтгэлгээ, түүний дотор улс төрийн онол, түүний нийгэм–улс төрийн ач холбогдол, үүрэгт итгэлгүй, сөрөг ханддаг байна. Солсберийн бүлгийнхэн өөрснөө үндсэндээ академийн судалгааны хүрээнийхэн байсан хэрнээ улс төрийн онол, үзэл санааг улс төрийн практикийг шимэн сорж байдаг паразит шинжтэй “хоёрдугаар зэргийн” зүйл гэж үзжээ. Эдгээр үзэл, хандлагыг консерватив үзэлтэн М.Коулинг “сэхээтнүүд ер нь хангалттай хор хохирол учруулсан, одоо дуугүй болох хэрэгтэй” гэсэн үгээр илэрхийлжээ. Нийт консерватизм болон түүний дотор соёлын консерватизмын эл байр суурь нь улс төрийн өрсөлдөөн, маргааны явцад өөрсдөд нь эсрэгээр эргэж, либералистууд ба социалистуудад байр суурь, санаачилгаа алдахад хүргэж байв.

Английн орчин үеийн консерватив онолын томоохон төлөөлөгчийн нэг бол Майкл Оакшотт юм. Тэрбээр “Туршлага ба түүний хэв маягууд” (1933), “Улс төр дэх рационализм” (1962), “Хүний үйл байдлын тухай” (1976), “Шашин, улс төр ба ёс суртахууны амьдрал”, “Орчин үеийн Европ дахь ёс суртахуун ба улс төр” зэрэг зохиол, эссегээрээ консерватив сэтгэлгээний хөгжилд чухал хувь нэмэр оруулсан байна. Түүний консерватив үзэл баримтлал юуны өмнө, хүний оюун ухааны хүч чадалд итгэж эрхэмлэсэн Соён гэгээрүүлэлтийн гол үзэл санааны эсрэг чиглэж, шүүмжлэн няцаахад зориулагджээ. Оакшотт, хүн оюун ухаандаа тулгуурлаж зорилго тавьдаг, түүнийгээ хэрэгжүүлэх арга хэрэгсэлийг ухаалаг сонгож үйлдэх шалтгаан – үр дагаварын хэлхээ холбоо бүхий зарчмаар үйл ажиллагаа явуулна гэдэгт итгээгүй бөгөөд энэ нь тэрбээр консерватизмын уламжлалт үзэл санаа, суурь үндэслэлийн нэг болох оюун ухаан, рационализмыг эсэргүүцэн няцаах явдлыг баримталсан хэрэг байв. Түүний үзлээр оюун ухаан бол шашны үнэн, үзэл номлолыг ойлгож ухаарах, тухайн нийгмийн уламжлалт байгуулал, түүний хэвшин тогтсон язгуур угсаа, анги давхрааны ухаалаг, зүй зохистой зохион байгуулалт, дэг журмыг үзэж ойлгох, үнэлэхэд чухлаар хэрэг болж ашиглагдах ажээ. Нийгмийн байгууллын тогтвортой байдалд уламжлал асар их үүрэгтэй бөгөөд тэрээр хөгжил дэвшилд саад тушаа болохгүй, хүний аж төрөх ёсны хэв загвар болдог.

Улс төрийн бодлогыг нийгмийг өөрчлөх технологи болгон хэрэглэж огт болохгүй, өөрөөр хэлбэл улс төрийн бодлогын зорилго, арга хэрэгсэлийг оюун

ухаанаар урьдчилан тодорхойлж, сонгож болохгүй. Тийм оролдлого нийгэмд осол учруулна. Гэхдээ улс төрийн бодлого дан эмпирик, туршлагын чанартай байх ёстой гэж үзэж хараахан болохгүй, тэрээр нийгмийн тогтож хэвшсэн байгууллын хүрээн дэх өргөн утга агуулгатай, янз бүрийн хүсэл хүлээлт, ойлголт төлсөөлөл, хэрэгжих, хэрэглэж болох арга замыг тооцож анхаарсан байвал зохино гэж Оакшотт үзжээ. Түүний үзлээр улс төрийн философи хэрэгтэй бөгөөд тэрээр нийгмийн байгуулал, түүний улс төрийн зохион байгуулалт ямар байх ёстойг санаагаар урьдчилан заах биш, харин улс төрийн амьдралын байгаа бодит байдал, практикийг ойлгон илэрхийлэх, өөрийгөө түүнтэй ижилсүүлэх (идентификация) зорилготой ажээ. Гэхдээ Оакшотт хожмын үед бичсэн “Итгэхүйн улс төр ба үл итгэхүйн улс төр” гэсэн эссе зохиолдоо орчин үеийн улс төрийн бүх философи төрийг яаж удирдах вэ, төр ямар байх ёстой вэ гэсэн үзэл санааг тодорхойлон гаргахыг оролдсон өрсөлдөөнөөр боловсрогдон бий болсон гэжээ. Энэ нь орчин үеийн улс төрийн философийн авч үздэг нийтлэг асуудал бол төр, төрийн удирдлага ямар байвал зохих вэ гэсэн асуудал байгааг тэрээр заасан хэрэг юм.